ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ: ОНОЛ, ПРАКТИК, ЧИГ ХАНДЛАГА

Улаанбаатар
2025 он

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ: ОНОЛ, ПРАКТИК, ЧИГ ХАНДЛАГА

(Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)

Хянасан:	С.ГАНТУЛГА Дотоод хэргийн их сургуулийн Дэд бөгөөд Эрдэм шинжилгээ, инновацын газрын захирал, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хурандаа
Эмхэтгэсэн:	А.МАРАЛ Дотоод хэргийн их сургуулийн Ахисан түвшний сургалт, судалгааны албаны дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, цагдаагийн дэд ахлагч
Хэвлэлийн эх, хавтасны дизайн:	Б.ТУЛГА Дотоод хэргийн их сургуулийн Хэвлэл, редакцын албаны эх бэлтгэгч-дизайнер
Цаасны хэмжээ:	B5
Хэвлэлийн хуудас:	16.6 хх

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

Та бүхэнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 60 жилийн ойн баярын мэнд дэвшүүлж, ойн хүрээнд зохион байгуулж буй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил: Онол, практик, чиг хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирж, оролцож, судалгааны үр дүнгээ танилцуулсанд Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлье.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал нь аливаа улсад эрх зүйт ёсыг бэхжүүлэх, шударга ёсыг хамгаалах, тогтвортой хөгжилд хөтлөх, хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах тулгуур юм.

Ийм учраас сүүлийн жилүүдэд улс орнууд гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох ажиллагаатай зэрэгцүүлэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлийг судлан тогтоож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд түлхүү анхаарч, энэхүү ажлыг судалгаанд суурилан техник технологийн дэвшлийг ашиглан зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг төрийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудыг чадавхжуулах, гадаад улсын болон олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр зорин ажиллаж байгааг онцлон тэмдэглэе.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн төрийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг. Цаашид бид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг онолд суурилан, практикт тулгамдаж буй сорилт бэрхшээлийг судалж, олон талт хамтын ажиллагаанд тулгуурлан зохион байгуулах шаардлагатай байна.

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлаар криминологийн шинжлэх ухааны хөгжил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлыг онол, практикийн түвшинд өргөн хүрээтэй хэлэлцэх замаар төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд харилцан туршлага солилцох, гадаад улсын

туршлагаас хуваалцах, хамтын ажиллагааг сайжруулах чухал талбар болж байгаад Зохицуулах зөвлөлийн даргын хувьд баяртай байна.

Энэхүү эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл, судалгааны үр дүн нь криминологийн шинжлэх ухааны хөгжлийг дэмжих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, стратеги, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг сайжруулах, иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Хүн төвтэй, аюулгүй, шударга нийгмийг цогцлоох үйл хэрэгт та бүхний санал, бүтээл бүхэн үнэ цэнтэй байх болно.

Олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулагч Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Дотоод хэргийн их сургууль, энэхүү хуралд судалгааны үр дүнгээ танилцуулсан гадаадын болон үндэсний их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн судлаач, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамт олонд дахин талархал илэрхийлье.

Та бүхний ажилд амжилт хүсье.

Л.МӨНХБААТАР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

МОНГОЛ УЛС ДАХЬ КРИМИНОЛОГИЙН УЛАМЖЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

С.НАРАНГЭРЭЛ
Монгол Улсын Шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт, Академич

Хураангуй: Энэ илтгэлд XIII зууны үеийн Монголын амар амгалан буюу Pax Mongolica-гийн ирэн үед криминологийн сэтгэлгээний өв уламжлал ямар байсан тухай товч хөндөх болно.

Латины “crimen” буюу гэмт хэрэг, грекийн “logos” буюу сургаал гэсэн үгээс “криминологи” гэсэн нэр томьёо үүссэн бөгөөд “гэмт хэргийн тухай шинжлэх ухаан (сургаал)” хэмээсэн утга санааг илэрхийлж иржээ. Энэхүү “криминологи” гэсэн нэр томьёог анх бие даасан шинжлэх ухаан гэсэн утгаар “Криминологи” хэмээсэн нэртэй нэг сэдэвт бүтээлийг 1885 онд хэвлүүлсэн Италийн зохиогч Топинард ба Гарофало нар хэрэглэсэн юм.

Криминологи нь гэмт явдал, гэмт хэрэгтэн бие хүн, гэмт явдлын шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам ба хэрэглүүрийг судалдаг социологи-эрх зүйн хавсарсан шинжлэх ухаан билээ.

Түлхүүр үгс: Чингис хаан, Монгол, Криминологи, гэмт явдал, ёс суртахуун,

Өнөө үед орчин цагийн криминологийн шинжлэх ухааны судлах зүйлийг гэмт явдал, гэмт хэрэгтэн бие хүн, гэмт явдлын шалтгаан нөхцөл, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх гэсэн дөрвөн үндсэн хэсгээс бүрддэг гэж үзэж байна. Тэгвэл эртний монголд эдгээр дөрвөн зүйлийг ёс суртахуунтай шууд холбож үздэг байжээ. Ёс суртахуун нь криминологийн өнө эртний уламжлал, сэтгэлгээ байсан болох нь нэгэнт хүлээн зөвшөөрөгдөөд байна[1]. Зарим монгол судлаач гэмт хэргийн шалтгааныг ёс суртахуунтай холбон судлах болжээ[2].

Ази тивийн суут мэргэдийн сургаалд ёс суртахууны тухай “Хаан хүмүүн хааны ёсоор, сайд хүмүүн сайдын ёсоор, эцэг эхийн ёсоор, хүү хүүгийн ёсоор байваас зохих бөлгөө”[3] хэмээн бичсэн байдаг юм. - Хөвгүүн нь эцгийнхээ сургаалыг дуулдаггүй, дүү нь ахынхаа үгийг тоодоггүй, эхнэр нь эрийнхээ хэлснийг дагадаггүй, хадам нь бэрээ хайрладаггүй, бэр нь хадмаа ойшоодоггүй, том нь багаа хүмүүжүүлдэггүй, бага нь томынхоо сургамжийг

[1] Зүмбэрэллхам Д. Криминологийн онол. Улаанбаатар., 2022, 29-39 дэх талыг үзнэ үү.
[2] Хууль зүйн ухааны доктор Б.Мөнх-Эрдэнэ “Ёс суртахуунгүй үйлдэл нь хүмүүсийн бие махбод, сэтгэл зүйд таагүй мэдрэмжийг төрүүлэх дараах сөрөг нөхцөл үүсгэдэг: I. Бие махбодын хор хөнөөл: гэмтэл, өвчин өвдөлт зэрэг орно. II. Сэтгэл зүйн хохирол: үнэ цэнгүй болох, сэтгэлийн зовуурь, гэм буруутай мэт мэдрэмж авах, уур хилэн, айдас зэрэг мэдрэмжүүд төрөх. III. Хувийн үнэ цэнийг үнэгүйдүүлэх: бусад хүмүүс доромжлох, залилах бусад хэлбэрээр үл хүндэтгэх, шударга бус хандах зэрэг сөрөг үзэгдэл бий болно. – Мөнх-Эрдэнэ Б. Гэмт хэрэг судлалын онол. Улаанбаатар., 2001, 132 дахь тал.
[3] Күнз Шүүмжлэл өгүүлэл. Хятад хэлнээс орчуулсан М.Чимэдцэеэ.., Улаанбаатар., 2013, 117 дахь тал.

хайхардаггүй, эзэн нь харцынхаа дотно сэтгэлийг татдаггүй, баян нь эд хөрөнгийг хураавч, ханаж цадах гэх юмыг огт мэдэхгүй, төр ёс (yosun), хуулийг (yasag) оюуны чадлаар, мэдлэгийн хүчээр ойлгодог нь үгүй болсны уршгаар тэр иргэний дотор дээрэмчин, тонуулч, луйварчин гаарч, хүн ардыг гэрээс нь хөөж туун, алан хядаж, талан тонож, адуу малыг нь ч үймүүлэн бужигнуулж, агт морьдыг арьс махтай нь хатаамуй хэмээн Чингис хаан айлдсан[1] гэж Судрын чуулганд[2] бичиж үлдээжээ.

Тэнд мөн Чингис хааны од нь гийж, хотлыг захиран эрхшээх болохдоо хатуу чанд Засгаараа тэднийг журамлан, сэцэн мэргэн хийгээд чин зоригтойг нь цэргийн ноён болгох, ажилсаг шаламгайг нь уурга бариулаад агтчинаа болгож, ажилгүй мунхгийг нь ялихгүй ташуурдаад хоньчноор илгээсэн. ... Хожим таван зуун жил, мянган он, түмэн оныг хүртэл намайг залгамжлах миний хойч үе төрөн гараад хаан төрийг барихдаа Чингисийн ёсон (yosun) [ёс суртахуун С.Н.] засгийг (yasag) [хууль. С.Н.] үл өөрчилж, хадгалан баримтлах аваас Мөнх тэнгэр хишгээ хүртээж, тэд маань өнө мөнхөд гэр хотлоороо энх амар, төрөл саднаараа түвшин жаргалтай байх болмуй заа[3] хэмээн бичжээ.

Энд бичсэн Чингис хааны ёс суртахуун гэж чухам юуг хэлсэн юм бол. Энэ хорвоогийн хүмүүний ёс суртахууны эрхэм дээд зан чанарын цогц нь ёс суртахуун юм. Тэдгээрийг ой санамждаа шингээсэн хүмүүн гэмт хэрэг үйлдэггүй ажээ. Энэ бол юуны өмнө шударга ёс бөгөөд Чингис хаан "гүр улсыг[4] шударгатаж гагц жолоондоо оруулсан"[5] гэж айлдсан нь Монголын нууц товчооны 224 дүгээр зүйлд тэмдэглэгдэн үлджээ. Энэ бол нинжин сэтгэл буюу ийм сэтгэлтэй хүн хэзээд ч бусдын амь насанд халддаггүй, эрүүл мэндэд гэмтэл учруулдаггүй, айлган сүрдүүлдэггүй, хүчирхийлдэггүй, бусдын нэр төрд халдаж доромжилж гутаадаггүй, танхай балмад авирладаггүй ажээ.

Ёс суртахуун бол эс шунах сэтгэл бөгөөд ийм хүмүүн шуналтдаггүй, бусдын өмч хөрөнгөд халддаггүй, шунахай сэдэлтээр албан тушаалынхаа байдлыг урвуулан ашигладаггүй, хахууль хэзээ ч авдаггүй юм. Итгэл даадаг хүн хүнийг хэзээ ч залилан мэхэлж хулхидахгүй. Атгаг сэтгэлгүй, өс хонзон санадаггүй хүмүүн бусдад хор хөнөөл учруулдаггүй.

Үүрэг ба хариуцлагаа гүнээ ухамсарладаг аливаа болзошгүй аюулаас үргэлж сэрэмжилж явдаг. Энэ учраас монголчууд эрт дээр үеэс гэмт явдал аливаа хүмүүн ёс суртахуунгүй авирласнаас үүдэгддэг хэмээн номлож, үр

[1] Рашидадин Фазлуллах Шашдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой. Дэд боть. Англи хэлнээс орчуулж, Уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Хатиган Готовын Аким..., хоёр дахь хэвлэл.., Улаанбаатар., 2015, 447-448 дахь талыг үзнэ үү.

[2] Судрын чуулган Персийн их бичгийн хүмүүн Рашид-ад-диний хувийн зохиол бус харин Чингис хааны отгон хөвүүн Толуйгийн гуравдугаар хөвүүн Ил хаант улсын хан Хүлэгү-г залгамжилсан бага хаад Хасан, Өлзийт хааны үед зарлиг гаргаж, монголын түүхийг эртний персээр хэлээр 1300-1311 оны хооронд бичүүлсэн монголын албан ёсны түүхийн бүтээл ажээ.

[3] Мөн тэнд, 448 дахь тал.

[4] "Гүр улс" гэсэн нь нийт улс гэсэн утгыг илэрхийлжээ.

[5] Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо. Улаанбаатар., 2024, 516 дахь тал.

хүүхдэдээ "Муу юм энэ ертөнцөд олон боловч, Муу хүнтэй адил аюулт юм ер үгүй"[1] гэж үргэлж захиж хэлж, ой санамжид нь суулгаж иржээ.

Монголын ард түмний олон зууны туршид дагаж мөрдсөн бичмэл бус хууль болох "хайр нь дотроо, хална гаднаа" гэсэн зүйр үг үр хүүхдээ сайн хүн болгохын чухлыг тусган илэрхийлдэг. Чингис хааны билэг сургаалд:

Балчир бага наснаасаа

Биеэ засан хүмүүжигтүн

Хүмүүжиж эс чадваас

Хүмүүн болж үл чадмой гэсэн байдаг.

Чингис хааны ээж Өүлэн эх "сайн хүн"[2] гэж байнга хэлдэг байжээ. Монголчууд хар нялхаас нь үр хүүхдээ сайн хүн болгохын төлөө хичээнгүйлэн чармайн зүтгэдэг байв. 1245-1247 онд Их Монгол Улсад Ромын папын зараалаар хүрэлцэн ирсэн Плано Карпина "хүүхэд багачууд бусдыг гомдоох аваас томчуул (эцэг эх С.Н. тодотгов) нь өмөөрч хаацайлах нь үгүй харин хатуу чангаар залхаан шавхуурдах бөлгөө"[3] хэмээн бичжээ. Чингис хаан "...зам, харгуйгаар урагшлахад нь эднийхээ хөлд тээглэж байгаа чөдөр өвс, өргөст бут зэрэг тээртэй бүхнийг нь арилгаж өгөх, тал бэлчээрт нь өмхий шарилж, өргөст өвс ургуулахгүй байх болой"[4] хэмээн айлдсан байдаг.

Сэтгэл зүрхээ ариусгаж чадсан хүмүүн гэмт хэрэг үйлддэггүй болохыг түүхэн эх сурвалжид тэмдэглэн үлдээжээ. Чингис хаан "Дотор сэтгэлээ ариусгаж чадсан хүн бүр гүр улсаа дээрмээс цэвэрлэж чадна"[5] хэмээн айлджээ.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудалд монголчууд онцгой анхаарал тавьж иржээ. Ганц нэгхэн жишээ дурдахад Монголчууд эртнээс ургийн бичиг хөтөлж ирсэн нь ёс суртахуунлаг, эрүүл хүүхэд төрүүлж өсгөх, цус холилдсоноос сэтгэцийн эмгэгтэй хүүхэд мэндлэхээс сэрэмжлэхэд чиглэгдэж байжээ. Монголчууд уг гарлаа Бөртэ чиногаас[6] эхлээд XIII зууны дунд үе хүртэл нарийвчлан дэс дараалалтайгаар дурдан өгүүлсэн нь Монголын нууц товчоонд тодорхой байдаг. Энэ нь монголчууд бүр эртнээс угийн бичиг хөтөлдөг байсныг нотлон харуулна. Судрын чуулганд "Бүх аймаг тус бүрдээ тодорхой угийн бичигтэй, учир нь монголчуудын заншил бол өвөг дээдсийнхээ уг удмыг хадгалан, шинэ төрсөн хүүхэд бүрд түүнийгээ зааж

[1] Сажа Бандид Гунгаажалцан Эрдэний сан Субашид. Улаанбаатар., 2009, 52 дахь тал.
[2] Монголын нууц товчооны 135 дугаар зүйлийг үзнэ үү.
[3] Жиованни дель Плано Карпина Монголчуудын түүх, Гильом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь. Орос хэлнээс орчуулсан С.Туяа, С.Цолмон.., Улаанбаатар., 1988, 25 дахь тал.
[4] Рашидадин Фазлуллах Шашдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой. Дэд боть. Англи хэлнээс орчуулж, Уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Хатиган Готовын Аким..., хоёр дахь хэвлэл., Улаанбаатар., 2015, 453 дахь тал.
[5] Мөн тэнд, 449 дэх тал.
[6] Чингис хааны хамгийн дээд өв - Үз.: Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо. Улаанбаатар., 2024, 37 дахь тал.

мэдүүлдэг болохоор дотор нь өөрийн аймаг уг гарлыг мэддэггүй нэг ч хүн байдаггүй. Арабчуудаас бусад олон аймгийн дотор монголчууд шиг гарлаа мэддэг ийм заншилтай аймаг огт байхгүй”[1] хэмээн бичжээ.

Архидан согтуурах явдал Чингис хааны эрин цаг үед гэмт явдал үүдэгдэх нэгэн гол шалтгаан болж байжээ. Чингис хаан “Архи, дарс уудаг хүн согтохдоо юу ч харж чадахгүй нүдэн балай больюу. Дуудахад дуулахгүй чихэн дүлий больюу. Үг хэлэхэд хариулахгүй хэл хөшүүн больюу. Хүн согтохдоо амьд байвч үхсэн мэт больюу. Цэх сууяа гэвч чадахгүй, толгойгоо сүхдүүлсэн шиг ухаан мэдрэлгүй, үлгэн салган больюу. Хүмүүний оюун санаанд ч, эрдэм мэдлэгт ч, сайн чанарт ч, сайхан аальд ч архины тус эрдэм гэж огт үгүй бөгөөд харин ч зодоон цохион хийх, хүн алж, хүрээ талахыг дарвисхийж, олсон зөөснийг үгүйрүүлж, сурсан мэдсэнийг мартуулдаг биш үү.

... Архи дарсанд орсон хаан ямар ч аугаа үйл бүтээж ч, мэргэн айлдвар айлдаж ч үл чадмуй, аугаа ёсыг тогтоож ч үл бармуй. Архи дарсанд шунасан ноён мянгат, зуут, аравтаа засаж ч, эхэлснээ дуусгаж үл дөнгөмүй. ... Эгэл харц архинд орвоос морь малаа барж, эд хөрөнгөө үгүйрүүлж, үгээгүй ядуу болмуй. Барлаг харц архинд шунаваас хамаг амьдралаа ичгүүр сонжуур, зовлон зүдгүүрийн дунд өнгөрөөх болмуй. Архи гэдэг согтсон хүний царай зүсийг ч, сэтгэл зүрхийг ялгахгүй, тэнэг байна уу, цэцэн байна уу гэж сонгохгүйгээр сайн мууг бүгдийг нь хөлчөөн баллах буюу. Гарыг юм өргөе гэхэд даахгүй, урлаж бүтээе гэхэд чадваргүй болгон сульдааж, хөлийг явъя гэхэд зөөгдөхгүй, хөдөлье гэхэд даагдахгүй болгон сулрааж, оюуныг сэтгэе гэхэд сэтгэхгүй болгон балайруулж, сэрдэг мэдэрдэг, хөдөлдөг барьдаг бүх эрхтнийг сандаадаг буюу”[2] гэж архидан согтуурахын хор уршгийг сэтгэл зүрхэнд хоногштол зүйрлүүлэн айлджээ. Эрхэм бээр архи дарснаас сэрэмжлүүлж “Ууж согтуурахаас сэргийлэх арга чарга үнэхээр үгүй аваас сард гурав уугууштай. Гурваас хэтэрвэл тун муу хэрэг. Сард хоёр уувал арай дээр, нэг уувал бүр сайшаалтай. Огт уухгүй байвал түүнээс сайн юм гэж хаа байх вэ”[3] хэмээн сургамжилжээ. Их эзэн Чингис хааны эл сургамж өнөө үед ач холбогдол, үнэ цэнээ алдаагүй байна.

Эдүгээ Монгол Улс дахь гэмт явдлын нөхцөл байдалд архидан согтуурах явдлын нөлөөлөл их байна. Тус улсад гарч буй таван гэмт хэргийн нэг нь согтуугаар үйлдэгджээ. Хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд танхайрах, бусдын эрүүл мэндэд санаатай халдсан гэмт хэргийн 90 шахам хувь архидан согтууралтай холбоотой байгаа болно. Дээрэмдэх дөрвөн гэмт хэргийн гурав нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн талаас илүү хувь нь, авто тээврийн гэмт хэргийн тал хувь нь согтуурлын нөлөөгөөр үйлдэгдсэн байна.

[1]Рашид-ад-дин Судрын чуулган. Орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлсэн Ц.Сүрэнохрлоо.., Улаанбаатар., 2002, 163 дахь тал.
[2] Мөн тэнд, 452 дахь тал.
[3] Мөн тэнд.

Гэмт хэрэг үйлдэхэд тус дөхөм үзүүлсэн нөхцөлд согтуу хохирогчийн эзлэх жин багагүй байна. Тухайлбал, хүчиндэх, ахуйн гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, танхайрал, авто тээврийн гэмт хэрэг үйлдэхэд согтуу хохирогч өдөөн турхирсан үүрэг гүйцэтгэсэн байна. Хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд авто тээврийн гэмт хэргийн гурван хохирогч тутмын нэг нь согтуу байсан тогтоогджээ.

Гэмт явдал хүмүүний ёс суртахуунаас голчлон үүдэлтэй хэмээсэн монголчуудын эртний сэтгэлгээ өнөө үед үнэ цэнээ огт алдаагүй бөгөөд криминологийн шинжлэх ухааны судалгааны нэгэн гол чиглэл болон судлагдан улам бүр хөгжинө гэдэгт миний бие ямагт итгэлтэй явдаг.

Эх сурвалжийн жагсаалт

1. Зүмбэрэллхам Д. Криминологийн онол. Уб., 2022.
2. Мөнх-Эрдэнэ Б. Гэмт хэрэг судлалын онол. Уб., 2001.
3. Күнз Шүүмжлэл өгүүлэл. Хятад хэлнээс орчуулсан Чимэдцэеэ М. Уб., 2013.
4. Рашидадин Фазлуллах Шашдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой. Дэд боть. Англи хэлнээс орчуулж, Уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн Хатиган Готовын Аким..., Уб., 2015.
5. Судрын чуулган Персийн их бичгийн хүмүүн Рашид-ад-диний хувийн зохиол бус харин Чингис хааны отгон хөвүүн Толуйгийн гуравдугаар хөвүүн Ил хаант улсын хан Хүлэгү-г залгамжилсан бага хаад Хасан, Өлзийт хааны үед зарлиг гаргаж, монголын түүхийг эртний персээр хэлээр 1300-1311 оны хооронд бичүүлсэн монголын албан ёсны түүхийн бүтээл ажээ.
6. Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо. Уб., 2024.
7. Сажа Бандид Гунгаажалцан Эрдэний сан Субашид. Уб., 2009.
8. Жиованни дель Плано Карпина Монголчуудын түүх, Гильом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь. Орос хэлнээс орчуулсан Туяа. С, Цолмон. С, Уб., 1988.
9. Чингис хааны хамгийн дээд өв - Үз.: Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо. Уб., 2024.
10. Рашид-ад-дин Судрын чуулган. Орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо.., Уб., 2002.

МОНГОЛ УЛС ДАХЬ КРИМИНОЛОГИЙН ӨНӨ ЭРТНИЙ СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГ

АКАДЕМИЧ С.НАРАНГЭРЭЛ

2025-09-30

ЭНЭХҮҮ ИЛТГЭЛД

XIII зууны үеийн Монголын амар амгалан буюу Pax Mongolica-гийн ирэн үед криминологийн сэтгэлгээний өв уламжлал ямар байсан тухай товч хөндөх болно.

КРИМИНОЛОГИ

Гэмт явдал, гэмт хэрэгтэн бие хүн, гэмт явдлын шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам ба хэрэглүүрийг судалдаг социологи-эрх зүйн хавсарсан шинжлэх ухаан билээ

КРИМИНОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУДЛАХ ЗҮЙЛ

- Гэмт явдал
- Гэмт хэрэгтэн бие хүн
- Гэмт явдлын шалтгаан, нөхцөл
- Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх

ЁС СУРТАХУУН НЬ КРИМИНОЛОГИЙН ӨНӨ ЭРТНИЙ УЛАМЖЛАЛ, СЭТГЭЛГЭЭ БАЙСАН БОЛОХ НЬ НЭГЭНТ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨӨД БАЙНА

СУУТ МЭРГЭДИЙН СУРГААЛД

Хаан хүмүүн хааны ёсоор,
Сайд хүмүүн сайдын ёсоор,
Эцэг эхийн ёсоор,
Хүү хүүгийн ёсоор байваас зохих бөлгөө...

СУДАРЫН ЧУУЛГАНД ТЭМДЭГЛСНЭЭР

Хөвгүүн нь эцгийнхээ сургаалыг дуулдаггүй,
Дүү нь ахынхаа үгийг тоодоггүй,
Эхнэр нь эрийнхээ хэлснийг дагадаггүй,
Хадам нь бэрээ хайрладаггүй,
Бэр нь хадмаа ойшоодоггүй,
Том нь багаа хүмүүжүүлдэггүй,
Бага нь томынхоо сургамжийг хайхардаггүй,
Эзэн нь харцынхаа дотно сэтгэлийг татдаггүй,
Баян нь эд хөрөнгийг хураавч, ханаж цадах гэх юмыг огт мэдэхгүй

СУДАРЫН ЧУУЛГАНД ТЭМДЭГЛСНЭЭР



Төр ёс (yosun), хуулийг (yasag) оюуны чадлаар, мэдлэгийн хүчээр ойлгодог нь үгүй болсны уршгаар тэр иргэний дотор дээрэмчин, тонуулч, луйварчин гаарч, хүн ардыг гэрээс нь хөөж туун, алан хядаж, талан тонож, адуу малыг нь ч үймүүлэн бужигнуулж, агт морьддыг арьс махтай нь хатаамуй...

ЁС СУРТАХУУН БОЛ

эс шунах сэтгэл

- **бусдын өмч хөрөнгөд халддаггүй**
- **шунахай сэтгэлгүй**
- **хахууль хэзээ ч авдаггүй**
- **залилан мэхэлдэггүй**
- **атгаг сэтгэлгүй**
- **өс хонзон санадаггүй**



Чингис хааны билэг сургаалд

Балчир бага наснаасаа
Биеэ засан хүмүүжигтүн
Хүмүүжиж эс чадваас
Хүмүүн болж үл чадмой

- Монголчууд эртнээс ургийн бичиг хөтөлж ирсэн нь ёс суртахуунлаг, эрүүл хүүхэд төрүүлж өсгөх, цус холилдсоноос сэтгэцийн эмгэгтэй хүүхэд мэндлэхээс сэрэмжлэхэд чиглэгдэж байжээ. Монголчууд уг гарлаа Бөртэ чиногаас эхлээд XIII зууны дунд үе хүртэл нарийвчлан дэс дараалалтайгаар дурдан өгүүлсэн нь Монголын нууц товчоонд тодорхой байдаг.

- Судрын чуулганд "Бүх аймаг тус бүрдээ тодорхой угийн бичигтэй, учир нь монголчуудын заншил бол өвөг дээдсийнхээ уг удмыг хадгалан, шинэ төрсөн хүүхэд бүрд түүнийгээ заах мэдүүлдэг болохоор дотор нь өөрийн аймаг уг гарлыг мэддэггүй нэг ч хүн байдаггүй. Арабчуудаас бусад олон аймгийн дотор монголчууд шиг гарлаа мэддэг ийм заншилтай аймаг огт байхгүй" хэмээн бичжээ



- Архи, дарс уудаг хүн согтохдоо юу ч харж чадахгүй нүдэн балай больюу.
- Дуудахад дуулахгүй чихэн дүлий больюу.
- Үг хэлэхэд хариулахгүй хэл хөшүүн больюу.
- Хүн согтохдоо амьд байвч үхсэн мэт больюу.
- Цэх сууяа гэвч чадахгүй, толгойгоо сүхдүүлсэн шиг ухаан мэдрэлгүй, үлгэн салган больюу.

- Хүмүүний оюун санаанд ч, эрдэм мэдлэгт ч, сайн чанарт ч, сайхан аальд ч архины тус эрдэм гэж огт үгүй бөгөөд харин ч зодоон цохион хийх, хүн алж, хүрээ талахыг дарвисхийж, олсон зөөснийг үгүйрүүлж, сурсан мэдсэнийг мартуулдаг биш үү.

- Архи дарсанд орсон хаан ямар ч аугаа үйл бүтээж ч, мэргэн айлдвар айлдаж ч үл чадмуй, аугаа ёсыг тогтоож ч үл бармуй.
- Архи дарсанд шунасан нрён мянгат, зуут, аравтаа засаж ч, эхэлснээ дуусгаж үл дөнгөмүй.
- Эгэл харц архинд орвоос морь малаа барж, эд хөрөнгөө үгүйрүүлж, үгээгүй ядуу болмуй.
- Барлаг харц архинд шунаваас хамаг амьдралаа ичгүүр сонжуур, зовлон зүдгүүрийн дунд өнгөрөөх болмуй.

- Эрхэмбээр архи дарснаас сэрэмжлүүлж "Ууж согтуурахаас сэргийлэх арга чарга үнэхээр үгүй аваас сард гурав уугууштай.
- Гурваас хэтэрвэл тун муу хэрэг.
- Сард хоёр уувал арай дээр, нэг уувал бүр сайшаалтай.
- Огт уухгүй байвал түүнээс сайн юм гэж хаа байх вэ" хэмээн сургамжилжээ.

Эдүгээ Монгол Улс дахь гэмт явдлын нөхцөл байдалд архидан согтуурах явдлын нөлөөлөл их байна. Тус улсад гарч буй таван гэмт хэргийн нэг нь согтуугаар үйлдэгджээ. Хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд танхайрах, бусдын эрүүл мэндэд санаатай халдсан гэмт хэргийн 90 шахам хувь архидан согтууралтай холбоотой байгаа болно.

Дээрэмдэх дөрвөн гэмт хэргийн гурав нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн талаас илүү хувь нь, автотээврийн гэмт хэргийн тал хувь нь согтуурлын нөлөөгөөр үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэхэд тус дөхөм үзүүлсэн нөхцөлд согтуу хохирогчийн эзлэх жин багагүй байна.

Тухайлбал, хүчиндэх, ахуйн гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, танхайрал, автотээврийн гэмт хэрэг үйлдэхэд согтуу хохирогч өдөөн турхирсан үүрэг гүйцэтгэсэн байна.

Хэсэгчилсэн судалгаанаас үзэхэд автотээврийн гэмт хэргийн гурван хохирогч тутмын нэг нь согтуу байсан тогтоогджээ.

БИ БЭЭР

Гэмт явдал хүмүүний ёс суртахуунаас голчлон үүдэлтэй хэмээсэн монголчуудын эртний сэтгэлгээ өнөө үед үнэ цэнээ огт алдаагүй бөгөөд криминологийн шинжлэх ухааны судалгааны нэгэн гол чиглэл болон судлагдан улам бүр хөгжинө гэдэгт итгэлтэй явдаг.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОНОЛЫН СЭТГЭЛГЭЭНИЙ УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ, МОНГОЛ УЛСЫН ТУРШЛАГА

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ
Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Монгол Улсын Гавьяат хуульч, Дотоод хэргийн их сургуулийн хүндэт профессор, доктор, профессор

Түүхэн замнал

Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг орчин үеийн чиг хандлагаар явуулж ирсэн түүхэн туршлагадаа ГХУСАЗЗ үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээг тохиолдуулан дүгнэлт хийж, цаашдын чиг хандлагаа тодорхойлох чухал арга хэмжээ болж байна. Манай улс коммунизмын үзэл суртлыг баримталж байсан социалист замналаас татгалзаж, ардчилсан хөгжлийн замыг сонгосноор хүн төрөлхтний хуримтлуулсан мэдлэг туршлагыг ямар нэгэн хязгаарлалт, хорио цээргүйгээр хуваалцах таатай боломж бүрдээд байна.

Марксизм ба радикал криминологийн онол

Энэ онол нь 20-р зууны ихэнх хугацаанд социалист орнуудын төрийн бодлогын үндэс суурь болж, хууль зүй, гэмт хэргийг тайлбарлах үндсэн арга барилыг тодорхойлж байв. Гэмт хэрэг бол зүгээр нэг гаж үзэгдэл бус, капиталист нийгэм дэх системчилсэн дарамт шахалтын эсрэг бодит хариу үйлдэл гэж үздэгээр марксизмын гол санаа илэрхийдэгддэг[1]. Энэ онолд хуулийг капиталист нийгмийн дээд ангийн эрх ашгийг хамгаалдаг хэрэгсэл гэж үзэх бөгөөд хууль зөрчих нь заримдаа хувь хүний ёс суртахууны сул тал бус, харин системийн дарангуйллын эсрэг тэмцэл байдаг гэж үздэг. Ийм учир шалтгаанаар социалист хууль ёсны үүднээс хуулийг социалист төрийн бодлогын зэвсэг гэж тодорхойлж байв[2].

Социалист орнуудад, тэр дундаа ЗХУ болон түүний нөлөөллийн орнуудад Марксист онолыг хууль тогтоомж, шүүхийн тогтолцоо, гэмт хэрэг судлалд шууд тусган хэрэгжүүлж байсны нэг нь манай улс юм. Монгол Улс социалист нийгмийн тогтолцооны үед зөвхөн энэхүү үзэл баримтлалыг удирдамж болгон гэмт хэргийг хувь хүний асуудал гэхээс илүүтэй нийгмийн ангийн ялгаанаас шалтгаалах үзэл суртлын үүднээс судалж, ийм байдлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, арга зүйгээ боловсруулж, хэрэгжүүлж ирсэн.

Коммунист үзэл суртал, түүнд нийцүүлсэн социалист эрх зүйн тогтолцооны үед хамгийн их хязгаарлагдмал ойлголтод хашигдаж байсан зүйлийн нэгэнд гэмт хэргийг ойлгох ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаа тооцогдоно. Учир нь тэр үед гэмт хэргийг марксизмд үндэслэсэн

[1] Teng, L. “Structural Inequality and Juvenile Delinquency: A Marxist Class Analysis.” Journal of Criminal Investigation and Criminology, 2025. p. 14–15.
[2] А. Я. Вышинский /Андрей Януарьевич Вышинский, СССР/, Право Советского государства /Москва: Изд-во иностр. лит., 1948/, с. 45

шүүмжлэлт радикал криминологийн онолыг дагнан судалж, энэ онолын үүднээс гэмт хэргийг тайлбарласан үзэл номлолоос өөр онолуудыг судалж, төрийн бодлого, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх явдал хориотой байсан. Хэдийгээр шинжлэх ухаанд криминологийн салбар үүсэж хөгжөөд маш олон онол, чиглэлүүд бий болсон байсан ч гэсэн тэдгээрийг зөвхөн капитализмыг зөвшөөрдөг нийгэмд зориулагдсан гэж үзэх, тэдгээрээс эрс татгалзах ёстой байлаа.

Тухайлбал, тэр үеийн МХЗЭ-ийн дүрэмд "...нийгмийн эрх ашгаас гажих, хэв журам зөрчих явдалтай эвлэршгүй тэмцэхийг залуу хүн нэг бүрийн үйл амьдралд мөрдлөг болгохыг зорьж, социализмд харш үзэл, зан заншил, хүмүүсийн ухамсар ахуйд үлдсэн бусдын хөдөлмөрийг завших, эд мөнгөнд шунах, амин хувиа бодох, эрх тушаал хөөцөлдөх, нүд хуурах зэрэг хуучин нийгмийн үлдэгдэл, хувийн өмчтөний үзэл санааны элдэв илрэлийн эсрэг эрс шийдвэртэй тэмцэх ажлыг бүхий л талаар өрнүүлэх" ёстойг онцлон дурдсан байдаг. Манай улсад гэмт хэргийг хуучин нийгмээс хүний ой ухамсарт үлдсэн бурангуй үзлээс үүдэлтэй гэж оношлоод социализм төгөлдөржихийн хэрээр үзэл алга болох ёстой, гэмт хэрэг ч байхгүй болно, тэр цагийг хурдан авчрахын тулд хамтаараа шийдвэртэй тэмцэх ёстой гэсэн үзэл, үүнд нийцсэн арга хэлбэрээр урьдчилан сэргийлэх ажлыг явуулж байсан түүх ард үлдээд 30 гаруй жил боллоо.

Гэхдээ 1970-аад оны дунд үе гэхэд радикал криминологи нь марксист, нийгмийн зөрчлийн болон шүүмжлэлт онолуудыг нэгтгэсэн онолын чиглэл болж төлөвшсөн бөгөөд нийгмийн бүтцийн шударга бус байдал, хууль тогтоох үйл явц дахь нийгмийн давхаргын давамгайлал, төрийн зохион байгуулалттай хүчирхийллийг гэмт хэргийн нэг хэлбэр гэж үздэг өнөөгийн шинэ чиглэл болон үргэлжилж байгааг тэмдэглэх нь зүйтэй.[1] Коммунизмын үзэл санааны улмаас хэт туйлшруулан удирдамжаа болгож байсан үзэл орчин үеийн нөхцөл байдалд нийсэн байдлаар шинэчлэгдэн хөгжих байгааг бид тооцохгүй байж болохгүй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг орчин цагийн нөхцөл байдалд нийцүүлэн зохион байгуулж явуулахдаа энэ талаар хуримтлагдсан хүн төрөлхтний мэдлэгийн санг бүтээлчээр ажиглаж, криминологийн онол, чиглэлүүдийг системтэй судалж, үйл ажиллагаандаа өргөн хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Криминологийн хөгжил ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүй

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал нь криминологийн шинжлэх ухааны үндсэн судлагдахууны нэг билээ. Үүнийг үр дүнтэй

[1] Reigel, C.D. Radical Consent: The Origins of the Antioch College Sexual Offense Policy. ProQuest, 2025. p. 21.

хэрэгжүүлэхийн тулд гэмт хэргийн үүсэлд нөлөөлөх шалтгаан, нөхцөлийг бодитой тодорхойлох нь туйлын чухал бөгөөд хүн төрөлхтөн энэ тухай ойлголтыг олон янзаар тайлбарлаж ирсэн нь өнөөдөр ч үргэлжилсээр байна.

Ойлголт нэг мөр бус байсны учир нь тухайн түүхэн цаг үеийн нийгмийн хөгжил, зохион байгуулалтын хэлбэр, амьдралын хэв загвар, нийтээр хүлээн зөвшөөрсөн соёл, эрх зүйн зохицуулалт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байсан бөгөөд энэ нь криминологийн шинжлэх ухаанд өөр хоорондоо ялгаатай онол, чиглэлүүдийн бий болоход хүргэсэн. Гэсэн хэдий ч эдгээр ойлголтын зөрүү сүүлийн жилүүдэд багасах хандлагатай болж ирж байгаа нь гэмт явдлыг судлах эрдэм шинжилгээний үр дүнг даяаршлын орчинд өргөн хүрээнд хүртэх болсонтой холбоотой эерэг өөрчлөлт юм.

Криминологийн онолын уламжлалууд нь бүх цаг үед хуримтлагдсан мэдлэг дээр тулгуурлан үндсэндээ цөөн хэдэн асуудалд төвлөрдөг. Үүнд: гэмт хэрэг үйлдэгчид хууль зөрчихдөө өөрийн хүсэл зоригоос үл хамаарах хүчин зүйлийн нөлөөн дор үйлддэг үү; эсвэл нийгмийн зарим бүлэг хэсгүүд бүтэц, тогтолцооны хүчин зүйлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдэхэд түлхэгддэг үү; хүн ухамсарт чөлөөт сонголтоо хийсний үндсэн дээр өөрийн хүсэл зоригоор гэмт хэрэг үйлддэг үү; эсхүл төрийн эрх мэдэл, хууль тогтоомжийн хүрээнээс тодорхой хэмжээнд хамаардаг уу гэх мэт асуултууд багтдаг.

Эдгээр асуултад олсон хариултын бодитой байдал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын амжилтад шууд нөлөөлдөг учир энэхүү үзэгдлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах, олон улсын хэмжээнд хуримтлагдсан онолын мэдлэгийг практикт үр дүнтэй ашиглах нь улам чухал болсоор байна.

Иймд энэхүү илтгэлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онолын нийтлэг уламжлал, шинэчлэлийн чиг хандлага, Монгол Улсад авч хэрэглэх боломжийн талаар тусгахыг зорьсон болно.

I. Соён гэгээрлийн үе ба Сонгодог сургаал /XVIII зуун/

Европын соён гэгээрлийн үе нь хүний эрх, эрх чөлөө, байгалийн хууль болон рациональ үзэлд тулгуурласан эрх зүйн шинэчлэлийн эхлэлийг тавьсан эдийн засаг, улс төр, философийн өргөн өөрчлөлтийн зуун байв. Гэсэн хэдий ч энэ үед олон оронд абсолютизмын уламжлал, хатуу ял шийтгэл, тухайлбал шатаах, цаазлах, шоронгийн аймшигт нөхцөл зэрэг дундад зууны үлдэгдэл арга хэлбэрүүд хадгалагдсаар байсан бөгөөд эдгээрийг хүнлэг, хууль ёсны зарчимд нийцүүлэн шинэчлэх шаардлага тулгарчээ. Ийм нөхцөлд хүний эрх, эрх чөлөөний тухай философид тулгуурласан Беккариа, Бентам нарын үзэл санаа нь нийгмийн шинэчлэлийн онолын суурь болсон байна.

Сонгодог сургаалын гол төлөөлөгчдийн нэг Чезаре Беккариа /Итали/ өөрийн алдарт “*Гэмт хэрэг ба шийтгэл*” бүтээлдээ гэмт хэргийг хувь хүний рациональ сонголтын үр дүн гэж тайлбарлажээ. “Хэрэв гэмт хэргээс хүртэх ашиг нь шийтгэлийн цээрлүүлэлтээс их гэж тооцоолбол хүн түүнийг

үйлдэхэд хүрнэ”[1] гэж тэрээр үзсэн байдаг. Тиймээс шийтгэлийн зорилго нь өшөө авах бус, харин нийгмийн гэрээг хамгаалах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэх ёстой, шийтгэл хуульд нийцсэн, зайлшгүй, зохистой байх ёстой, хууль тодорхой байх ёстой гэх зарчмууд нь хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд тусгагдаж, өнөөгийн хууль тогтоомжийн үндсэн шаардлагуудын нэг болон төлөвшсөн.

Энэ сургаалын өөр нэг төлөөлөгч Иереми Бентам /Их Британи/ ютилитаризмын /*utilitarianism*/ үзлийг хөгжүүлсэн. Түүний онолын гол зарчим бол “хамгийн олон хүнд хамгийн их аз жаргалыг бий болгох” /*“the greatest happiness of the greatest number”*/ явдал.[2] Тэрээр хууль, бодлого, шийдвэр бүрийг гаргахдаа хүний амьдралд хэр их таашаал /*pleasure*/, хэр их зовлон /*pain*/ авчрахыг тооцох ёстой гэж үзжээ. Хууль тогтоомж бол хүний зан үйлийг нийтлэг ашиг сонирхолд нийцүүлэх гол хэрэгсэл бөгөөд шийтгэл нь зөвхөн урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг гарахаас хамгаалах зорилготой байх ёстой. Харин шийтгэл өөрөө нийгэмд илүү хор хохирол авчирвал ашиггүй, ёс суртахуунгүй гэж тэр дүгнэсэн нь өнөө цагт ч ач холбогдолтой хэвээр байна.

Ийнхүү Европын соён гэгээрлийн үеийн сэтгэгчид хууль цааз, шийтгэлийг хүний эрх ба байгалийн хуулийн зарчимд нийцүүлэхийг зорьсон нь тухайн үедээ орчин үеийн криминологийн суурь болсон сонгодог сургаалын /*Classical School of Criminology*/ эхлэлийг тавьсан бөгөөд энэ нь өнөөдөр дэлхийн олон улсын эрх зүйн тогтолцоонд уламжлал болон хөгжиж ирсэн.

II. Позитивизмын эрин /XIX зуун/

XIX зуунд позитивизм хүчээ авч гарч ирсэн нь тухайн үеийн нийгмийн хөгжлийн онцлогтой салшгүй холбоотой байлаа. Үйлдвэржилт, хотжилтын эрчимжилтээс улбаалан шинэ төрлийн гэмт хэрэг бий болж, шинжлэх ухаанд биологи, анагаах ухаан, статистикийн аргууд хүчтэй хөгжсөн бөгөөд социологийн шинжлэх ухааны суурь тавигдсан нь гэмт хэргийн судалгаанд шинэ эргэлт авчирсан байна.

Позитивизм гэмт хэргийг шалтгаант хамаарал бүхий нийгмийн бодит үзэгдэл гэж хүлээн зөвшөөрдөг. Энэ онолын үүднээс хүнийг зөвхөн рациональ сонголт хийдэг субъект гэж үзэхээс илүүтэйгээр, түүний зан авирыг биологийн, сэтгэлзүйн, нийгмийн хүчин зүйлсийн нийлбэр үр дүн гэж тайлбарласан. Иймээс гэмт хэрэг нь хувь хүний ухамсраас гадна түүний бие махбодын онцлог, нийгмийн орчин, эдийн засгийн нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг гэж үзсэн. Энэ утгаараа позитивизм нь сонгодог

[1] Cesare Beccaria /Итали/, *On Crimes and Punishments and Other Writings*, ed. Richard Bellamy, trans. Richard Davies /Cambridge: Cambridge University Press, 1995/, p. 34.
[2] Jeremy Bentham /Их Британи/, *An Introduction to the Principles of Morals and Legislation* /Oxford: Clarendon Press, 1907 [1789]/, p. 2.

сургуулийн шууд эсрэг биш, харин түүнийг шүүмжлэн залгамжилсан шинжийг агуулдаг.

Чезаре Ломброзо /Итали/: хүний гавлын яс, нүүрний хэлбэр зэрэг биеийн онцлог шинжийг судлаад "Төрөлхийн гэмт хэрэгтэн бол эртний хүний болон доод амьтдын зэрлэг шинжийг өөртөө хадгалан илэрхийлж төрсөн оршихуй"[1] гэсэн дүгнэлтийг хийсний үндсэн дээр "Төрөлхийн гэмт хэрэгтэн" /born criminal/ гэдэг онолоо дэвшүүлсэн.

Раффаэле Гарафало /Итали/: Гэмт хэргийг "нийгмийн цээр /табу/ эвдсэн үйлдэл" гэж тодорхойлж, бүх нийгэмд хор уршигтай, нийтээр хориглодог үйлдэл /crimen naturale/ гэсэн ойлголтыг дэвшүүлсэн. Тэрээр гэмт хэргийг тухайн нийгмийн жирийн хүнд нийтлэг байдаг шударга ёс, энэрэн нигүүлсэхийн хүнлэг мэдрэмжийг доромжилдог ёс суртахуунд харш үйлдэл хэмээн тодорхойлсон.[2]

Энрико Ферри /Итали/ бүтээлдээ гэмт хэрэг үйлдэгддэг учир шалтгааныг зөвхөн биологийн бус, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлсийн нийлбэрээр тайлбарласан. Тэрээр гэмт хэргийн шалтгааныг зөвхөн хувь хүний болон антропологийн бус, мөн байгалийн ба нийгмийн хүчин зүйлсээс хамааралтай бөгөөд гэмт хэргийн мөн чанарыг ойлгохын тулд эдгээрийг хамтад нь судлах шаардлагатай гэж тэмдэглэсэн.[3]

Эмиль Дюркхайм /Франц/ бүтээлдээ гэмт явдлыг нийгмийн зайлшгүй "хэвийн үзэгдэл" хэмээн тайлбарлаж, гэмт хэрэг бол хэвийн үзэгдэл, учир нь түүнээс ангид нийгэм оршин тогтнох боломжгүй...энэ нь зайлшгүй бөгөөд нийгмийн бүх амьдралын суурь нөхцөлтэй салшгүй холбоотой гэж дүгнэсэн.[4]

Сонгодог сургаал "яагаад шийтгэх ёстой вэ?" гэсэн философийн асуултад төвлөрч байсан бол, позитивизм "яагаад гэмт хэрэг үйлдэгддэг вэ?" гэсэн шинжлэх ухааны асуултад хариулт хайсан юм. Позитивизм гэмт хэргийн тухай судалгааг философийн түвшнээс шинжлэх ухааны түвшинд авчирснаар орчин үеийн криминологийн судалгааны арга зүй, ялангуяа эмпирик судалгаа, статистик шинжилгээ, олон хүчин зүйлд тулгуурласан хандлагын үндэс суурийг тавьсан билээ.

III. Нийгмийн бүтцийн ба Шошгололын онол /XX зуун/

XX зууны дунд үеэс криминологийн онол нь хувь хүний зан чанар болон биологийн хүчин зүйлсийг онцлохоос гадна нийгмийн бүтцийн зохион байгуулалт, эрх мэдлийн харилцаа, нийгмийн хариу үйлдлийн механизмуудад төвлөрөх болжээ. Энэ чиглэлээр хоёр томоохон урсгал төлөвшсөн нь нийгмийн бүтцийн онолууд /*Social Structure Theories*/ болон шошгололын онол /*Labeling Theory*/ юм.

---

[1] Cesare Lombroso Criminal Man /New York: Putnam, 1911 [1876]/, p. 72.
[2] Raffaele Garofalo Criminology /Boston: Little, Brown, 1914 [1885]/, p. 20.
[3] Enrico Ferri /Итали/, Criminal Sociology /Boston: Little, Brown, 1917 [1884]/, p. 45.
[4] Émile Durkheim /Франц/, The Rules of Sociological Method /New York: Free Press, 1982 [1895]/, p. 85.

1. Нийгмийн бүтцийн онолууд

• **Нийгмийн дэг зохион байгуулалтын онол** */Social Disorganization Theory/*: Клифорд Р. Шоу /АНУ/ болон Хенри Д. МакКей /АНУ/ нар Чикагогийн их сургуулийн судалгаагаар хотын тодорхой бүс нутагт гэмт хэрэг тогтвортой давтагддаг болохыг судалжээ. Тэдний дүгнэлтээр хөршийн хяналт буурах, гэр бүл, сургуулийн хүмүүжлийн нөлөө суларч, нийгмийн уялдаа алдагдсанаар гэмт хэрэг өсдөг гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.[1]

• **Нийгмийн зохион байгуулалт алдагдал ба нийгмийн дарамтын онол** */Anomie/Strain Theory/*: Роберт К. Мертон /АНУ/ Дюркхаймын нийгмийн зохион байгуулалт алдагдлын улмаас гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрддэг тухай "аномийн" ойлголтыг шинэчилж, нийгэм бүх хүнд ижил зорилго /жишээ нь эдийн засгийн амжилт/ тавьдаг ч түүнд хүрэх хууль ёсны боломжид тэгш бус байдал үүсэж боломж, зорилго хоёрын зөрчил үүссэнээс боломжгүй хэсэгт нийгмийн дарамт /страйн/ ирдэг тул зарим нь хууль бус аргыг сонгодог гэж тайлбарласан. Түүний бичсэнээр нийгэм нь зорилгод хүрэх хууль ёсны боломжийг тэгш олгохгүйгээр амжилтыг дээдэлбэл зарим хэсэг нь гажуудлын шинжтэй шинэ арга замыг сонгодог байна.[2]

• **Ерөнхий нийгмийн дарамтын онол** */General Strain Theory/*: Роберт Агню /АНУ/ нийгмийн дарамтын эх үүсвэрийг зөвхөн зорилгод хүрэх боломжгүй байдалд бус, хүсэмж зорилгоос хоцрох, үнэ цэнтэй зүйлийг алдах, таагүй нөхцөлтэй нүүр тулах зэрэг гурван хүчин зүйлтэй холбон тайлбарлажээ. Энэ нь хувь хүний бухимдал, уур хилэнг нэмэгдүүлж гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг өсгөдөг гэж дүгнэсэн.[3]

• **Дэд соёлын онол** */Subcultural Theories/*: Альберт К. Коэн /АНУ/ нийгмийн байр суурьиас шалтгаалсан бухимдал /status frustration/ хэмээх ойлголтыг дэвшүүлж, боловсрол, ажил эрхлэлтийн боломж хязгаарлагдсан залуучууд өөрийн гэсэн дэд соёл бий болгож гэмт хэргийн замаар ордог гэж үзсэн[4] бол Ричард А. Кловард /АНУ,/, Ллойд Э.Охлин /АНУ/ нар нийгмийн байр суурьиас шалтгаалсан бухимдал тэр бүр гэмт хэрэг үйлдэх шалтгаан болохгүй, харин түүнээс гадна гэмт хэрэг үйлдэх боломж хаана их байгаа ялгаанаас хамааралтай байдаг гэсэн агуулгатай "боломжийн ялгаатай байдлын онол"-ыг /differential opportunity theory/ хөгжүүлж, гэмт хэргийн боломж хаана ямар байгаагаас шалтгаалсан дэд соёлын бүлэглэл үүсдэг гэж тайлбарласан.[5]

---

[1] Clifford R. Shaw and Henry D. McKay /АНУ/, *Juvenile Delinquency and Urban Areas* /Chicago: University of Chicago Press, 1942/, p. 20–35.
[2] Robert K. Merton /АНУ/, "Social Structure and Anomie," *American Sociological Review* 3, no. 5 /1938/: p. 672–682.
[3] Robert Agnew /АНУ/, "Foundation for a General Strain Theory of Crime and Delinquency," *Criminology* 30, no. 1 /1992/: p. 50–60.
[4] Albert K. Cohen /АНУ/, *Delinquent Boys: The Culture of the Gang* /New York: Free Press, 1955/, p. 62–86
[5] Richard A. Cloward and Lloyd E. Ohlin /АНУ/, *Delinquency and Opportunity* /New York: Free Press, 1960/, p. 86–110.

2.Шошгололын онол /*Labeling Theory*/

1960-аад оноос эхлэн криминологийн судалгаанд шошгололтын онол /*labeling theory*/ гэх шинэ чиглэл бий болсон. Энэ онол нь гэмт явдлыг зөвхөн хувь хүний зан чанар эсвэл нийгмийн бүтэц, эдийн засгийн хүчин зүйлсээр тайлбарлахад хангалтгүй бөгөөд харин нийгмийн хариу үйлдэл болон эрх мэдлийн хүрээнд гаргасан шийдвэрээр гэмтэн гэсэн зориудын нэршил бий болгон эд барааанд шошго хадах мэтээр хүнд албадан нялзаадаг /labeling/ нь гэмт явдал өсөхөд нөлөөлдөг гэсэн агуулгатай. Энэхүү онолд дараах чиглэлүүд гол байр суурь эзэлдэг.

- **Муугийн драматизаци /*Dramatization of Evil*/**

Фрэнк Танненбаумын /АНУ/ үзсэнээр өсвөр насныхны жижиг зөрчлийг олон нийтийн өмнө “муу хүн” гэж тодорхойлох нь тухайн хүнийг гэмт хэргийн замнал руу түлхдэг бөгөөд энэ нь “анхдагч” зөрчлийг “хоёрдогч” гэмт хэрэгт шилжүүлэх процессын эхлэл болдог байна.[1] .

- **Анхдагч ба хоёрдогч гажуудлын онол /*Primary and Secondary Deviance*/**

Эдвин Лемерт /АНУ/ шошгололын талаар гүнзгийрүүлэн судалж анхдагч гажуудлыг түр зуурын, нийгмийн ноцтой шошгололгүй үйлдэл; хоёрдогч гажуудлыг албан ёсны, нийгмийн шошголол дагалдсанаас хувь хүний өөрийн үнэлэжийн ухамсар /self-concept/ өөрчлөгдөх явдал гэж ялгаад ингэж шошголох нь гэмт хэрэгтэн болох үйл явцыг идэвхжүүлдэг гэж үзсэн.[2]

- **Шошгололтын үзэл баримтлал /*Labeling Perspective*/**

Ховард Беккер /АНУ/ гэмт зан үйлийн тухай ойлголтыг өөр талаас нь авч үзэж шинэчилсэн. Тэр бээр бүтээлдээ “Гаж авир гэдэг нь хүний үйлдлийн мөн чанарт бус, харин бусад хүмүүсийн бий болгосон дүрэм, хоригийг хэрэгжүүлж тухайн хүнд “гэмтэн” гэсэн шошгыг амжилттай наасны үр дүн юм.”[3] гэсэн байдаг. Үүгээр гэмт хэрэгтэн болох үйл явц нь зөвхөн тухайн хүний үйлдэл бус, нийгмийн тодорхойлсон дүрэм, эрх мэдлийн тогтолцооны үр дүн гэдгийг Беккер дэвшүүлэн тавьсан бөгөөд гэмт хэрэг ба гаж авирын судалгааг хэм хэмжээ тогтоох эрх мэдэлтэй холбон тайлбарласан томоохон дэвшил байв.

- **Ялгаварлалын онол /*Stigma Theory*/**

Эрвинг Гофман /АНУ/ шошголол нь хувь хүний нийгмийн байр суурь, өдөр тутмын харилцаанд хэрхэн нөлөөлдгийг системтэйгээр судлаад “стигма” /*нийгмийн бүх төрлийн сөрөг үзэмж, ялгавартай хандлага*/ хэмээх ойлголтыг гаргаж, тодорхой нэг шинж /ял шийтгэлтэй байх, хөгжлийн бэрхшээл, угсаа гарал, бэлгийн чиг баримжаа гэх мэт/ нь нийгмийн нүдэнд “сөрөг үзэмж” болон хувирч, тухайн хүнийг “ердийн” хүмүүсээс ялгавартай

[1] Frank Tannenbaum, *Crime and the Community* /New York: Columbia University Press, 1938/, p.19–25.
[2] Edwin M. Lemert /АНУ/, *Social Pathology* /New York: McGraw-Hill, 1951/, p. 75–83.
[3] Howard S. Becker, *Outsiders: Studies in the Sociology of Deviance* /New York: Free Press, 1963/, p.8–10.

болгож харагдуулдаг гэж тайлбарласан.[1] Гофманы үзлээр ийм хүмүүс /stigmatized/ нийгмийн оролцоонд "адлагдах байдал"-тай */spoiled identity/* болж, ажил эрхлэлт, боловсрол, орон сууц зэрэг амьдралын чухал салбарт байнгын саад, ялгаварлалтай тулгардаг нь гэмт хэрэг үйлдэхэд бодитой нөлөөлдөг байна.

Ийнхүү XX зууны нийгмийн бүтцийн ба шошгололын онолууд нь гэмт хэргийг хувь хүний зан чанар, биологийн хүчин зүйлсээр бус, харин нийгмийн зохион байгуулалт, тэгш бус байдал, эрх мэдлийн бүтэц, нийгмийн хариу үйлдлээр тайлбарласан нь онолын шинэ дэвшил болжээ. Эдгээр онол нь орчин үеийн криминологийн онол, практикт нийгмийн илүү таатай орчин бүрдүүлэх, боловсрол, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, өсвөр үеийнхний ял шийтгэлийг аль болох багасгах, шүүхийн оролцоог хязгаарлах, шударга ёсыг нөхөн сэргээхэд /restorative justice/ чиглэгдсэн бодлогын үндэс суурь болж байна.

IV.Дижитал экосистем ба криминологийн шинэ чиглэлүүд /XXI зуун/

1970-аад оноос хойш криминологид хоёр гол чиг хандлага зэрэгцэн хөгжжээ. Нэг талаас сонгодог сургуульд тулгуурласан "рациональ сонголт" /Rational Choice/, "рутин үйл ажиллагаа" /Routine Activity/, "хагархай цонхны онол" /Broken Windows/ зэрэг шинэ сонгодог чиглэлийн онолууд /Neoclassical Perspectives/ хөгжиж, бодлого боловсруулахад шууд хэрэглэгдэх болсон. Нөгөө талаас хувь хүний хөгжлийн үзэл баримтлал бүхий "амьдралын замналын хандлага" /Life-Course Approach/, "өөрийгөө хянах чадварын онол" /Self-Control Theory/ нь гэмт зан авирыг хүний урт хугацааны хувьслын явцтай холбон судлах шинэ чиглэлийг нээсэн юм. Энэ хоёр чиглэл нийлж, өнөөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, стратегийн онолын үндэс болсон гэж үздэг.

1990-ээд оноос хойш орчин үеийн нийгмийн шинэ сорилтод хариу өгөх зорилгоор криминологийн шинэчлэгдсэн чиглэлүүд төлөвшин хөгжиж, уламжлалт онолуудыг баяжуулж ирэв. Үүнд "Соёлын криминологи" /Cultural Criminology/, "Ногоон криминологи" /Green Criminology/, "Өмнөдийн криминологи" /Southern Criminology/, "Биосоциологийн криминологи" /Biosocial Criminology/, "Нотолгоонд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа" /Evidence-Based Policing/ зэрэг чиглэлүүдийг дурдаж болно.

- **Соёлын криминологи /*Cultural Criminology*/**

Гэмт хэрэг нь зөвхөн хууль зөрчих үйлдэл бус, харин тодорхой утга, мэдрэмж, тэмцлийг илэрхийлсэн соёлын үйлдэл гэж үзэх нь соёлын криминологийн онолын агуулга юм. Хүмүүсийн гэмт авирт зөвхөн рациональ

[1] Erving Goffman, *Stigma: Notes on the Management of Spoiled Identity* /Englewood Cliffs, NJ: Prentice-Hall, 1963/, p. 3–12.

тооцоо биш, харин сэтгэл хөөрөл, адреналин, уур хилэн, баяр хөөр зэрэг соёлын мэдрэмж нь нөлөөлдөг[1] гэж энэ чиглэлийн онолчид үздэг.

- **Ногоон криминологи /*Green Criminology*/**

Гэмт хэрэг зөвхөн хүмүүсийн хоорондын асуудал биш, байгаль орчин, амьтан, ирээдүй хойч үеийн эрх ашигт ч хамаатай, хүний үйл ажиллагаа нь экологийн тогтвортой байдалд заналхийлж, амьдралын чанарыг доройтуулах ёсгүй гэсэн байр сууринаас амьтан ба экосистемийн эрхийг хамгаалах үзэл санаагаар ногоон криминологийн онол тодорхойлогдоно. Ногоон криминологи гэмт хэргийн судалгааг өргөжүүлж, хуульд гэмт хэрэг гэж заасан эсэхээс үл хамааран байгаль орчин болон амьтанд учруулсан хор уршгийг хамруулан экологийн шударга ёсны үүднээс авч үздэг байх байр суурийг энэ чиглэлийн онолчид баримталдаг.[2] Уур амьсгалын өөрчлөлт, экосистемийн сүйтгэл улам нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд ногоон криминологи нь байгаль орчин ба шударга ёсны огтлолцлыг нухацтай судлах шинэ чиглэл болоод байна.

- **Биосоциологийн криминологи /*Biosocial Criminology*/**

Биосоциологийн чиглэл нь өнгөрөгч зууны сүүл үеэс генетик, тархи судлал, зан төлөвийн биологи хурдтай хөгжсөнтэй холбогдон шинэчлэгдсэн чиглэл юм. Энэ чиглэлийн үүднээс гэмт авир нь зөвхөн ядуурал, боловсролын дутагдал, гэр бүлийн орчин гэх мэт нийгмийн бүтцийн нөхцөлөөс шалтгаалахгүй, харин генетик, тархи, гормон, мэдрэлийн онцлогтой хамсаж гэмт хэрэг үйлдэхэд нь нөлөөлдөг гэсэн байр суурийг биосоциологийн криминологчид баримталдаг. Өрөөр хэлбэл гэмт хэргийн шалтгаан нь зөвхөн биологид эсвэл нийгэмд дагаараа биш, харин тэдгээрийн харилцан үйлчлэлд оршино[3] гэсэн санааг эрдэмтэд дэвшүүлэн тавьсан байдаг.

- **Нотолгоонд суурилсан цагдаагийн үйл ажиллагаа /*Evidence-Based Policing*/**

Цагдаагийн практик үйл ажиллагаа, бодлого нь уламжлалт туршлага, улс төрийн шахалт, үүрэг даалгавраар бус, харин эмпирик нотолгоо, туршилтын үр дүн дээр суурилсан байх ёстой. Цагдаагийн байгууллагын өдөр тутмын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, нөхцөл байдлын судалгааг шинжлэх ухааны үндэстэй байнга хийж, туршилт явуулж, зөв мэдээлэлд суурилсан хамгийн үр ашигтай үйл ажиллагаа явуулахад энэхүү онол чиглэгддэг. Санамсаргүй хяналттай туршилт /RCT/ явуулах, өмнөх мэдээллүүдийг нэгтгэн мета-шинжилгээ хийх, гэмт хэргийн зураглал үйлдэх /crime mapping/, эрсдэлтэй халуун цэгүүдийг олж тодорхойлж эргүүл хийх /hot spots analysis/ зэрэг аргуудыг энэхүү онолын үүднээс санал болгодог.

---

[1] Jeff Ferrell, Keith Hayward, and Jock Young, *Cultural Criminology: An Invitation* /London: SAGE, 2008/, p. 15–40.
[2] Michael J. Lynch and Paul B. Stretesky, *Exploring Green Criminology: Toward a Green Criminological Revolution* /Farnham: Ashgate, 2014/, p. 5.
JOHN BRAITHWAITE
Австралийн Үндэсний Их Сургуулийн профессор, Ази, Номхон далайн Дипломатын Коллежийн хүндэт профессор

Australian National University

Crime Prevention Theory: Opportunities for Mongolia?

John Braithwaite
Australian National University

International Scientific Conference of the Coordination Council for Crime Prevention in Mongolia, October, 2025

Australian National University

Why is mass killing and political assassination more common in the United States that in the other most economically developed democracies?

Why is Latin America the region of the world with the highest homicide rate and the worst organized crime?

2

Australian National University



Free download:
http://johnbraithwaite.com

(Click on publications).

3

Australian National University

Violence is a cascade phenomenon. It must be prevented before it cascades out of control. That is why hot-spot policing can work.

But there are deeper historical causes, like the slave trade

The most fundamental root cause is domination. The most fundamental path to crime prevention is building a society that is free in the sense of free from as much domination as possible. Free of poverty, free of corruption.

That requires macro change inspired by the Constitutional architecture that Sun Yat-Sen wanted for his 1911 Republic of China. It was partially implemented in Taiwan when it became a democracy with an independent accountability and integrity branch of government.

To temper the power of domination, we need a more complex separation of powers today.

4

Australian National University

Evidence-based crime prevention is needed on all of these newer ways of thinking about prevention.

Let me illustrate with Australia's evidence-based journey of the effectiveness of ***Restorative Justice***.

5

Australian National University

Restore Victims, restore offenders, restore communities

With thanks to Rob Seward

Australian National University

Because crime hurts,

justice should heal

Australian National University

Canberra Restorative Justice Unit Values

- **Safety**
- **Accountability**
- **Empowerment**
- **Healing**

8

Australian National University

Passive Responsibility

Active Responsibility

J Braithwaite 2002 *Restorative Justice and Responsive Regulation,* Oxford University Press

Australian National University

One bigger vision

Restorative Practice is a way of thinking and being, focused on creating safe spaces for real conversations that deepen relationships and create stronger, more connected communities.

- Terry O'Connell

10

Australian National University

Restorative Practices: not just techniques

"We must be the change we wish to see in the world'

~ Mahatma Gandhi

With thanks to Rob Seward

Australian National University

Angel, Caroline M., Lawrence W. Sherman, Heather Strang, Barak Ariel, Sarah Bennett, Nova Inkpen, Anne Keane, and Therese S. Richmond. "Short-term effects of restorative justice conferences on post-traumatic stress symptoms among robbery and burglary victims: a randomized controlled trial." *Journal of Experimental Criminology* 10, no. 3 (2014): 291-307.

Australian National University

Survival Analysis: Canberra Violence experiment: Angel, Barnes et al



Australian National University

Literature Reviews on the Effectiveness of Restorative Justice

Latimer, Jeff, Craig Dowden and Danielle Muise (2001)
The Effectiveness of Restorative Justice Practices: A Meta- Analysis. Ottawa: Department of Justice, Canada.

Bonta, James, R. Jesseman, T. Rugge and R. Cormier (2006)
Restorative Justice and Recidivism: Promises Made, Promises Kept? In D. Sullivan and L. Tifft (eds.), *Handbook of Restorative Justice: A Global Perspective*. London: Routledge.

Sherman, Lawrence and Heather Strang (2007)
Restorative Justice: The Evidence. London: The Smith Institute.

Braithwaite, John (2002) *Macrocriminology and Freedom*. Canberra: ANU Press.

Australian National University

Implementing the agreement as an outcome

Effect sizes tend to be stronger for violent and serious offenders

This is a reason so many of the weakest effect sizes are for juvenile offenders

Lawrence Sherman and Sword of Damocles effects

15

Australian National University

Steep growth of different kinds of Restorative Justice in both the US and China



Source: Yan Zhang PhD and China Yearbook 1982 - 2015

Australian National University

In the United States, 70 percent of schools have a restorative justice program.

- US Department of Education official statistics (up until the department was abolished)

Australian National University

The volunteerism alternative to statist conceptions of Restorative Justice

Equiping every school child with restorative skills:

One Vision: Every school child is trained in how to be an effective participant and leader of restorative practices for school conflicts in primary school. Children who find they have talent and interest in being a well-trained restorative facilitator can do Restorative Practices as a high school subject for one term.

18

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР ДҮН

О.АЛТАНГЭРЭЛ
Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор, хууль цаазын шадар зөвлөх

ОРШИЛ

Прокурорын байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал, үр дүн

Прокурорын байгууллага байгуулагдаад 95 жил болох хугацаандаа хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол улсын 1940, 1960, 1992 оны үндсэн хуулиуд болон 1926 онд батлагдсан гарсан эрүүгийн хуулиас эхлэн өнөөдөр хэрэгжиж байгаа эрүүгийн хууль тогтоомж болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох прокурорын байр суурийг тодорхой заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дах хэсэгт төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлсон. Мөн арван зургаадугаар зүйлийн 2 дахь заалтад: “эрүүл, аюулгүй орчинд амьдрах,... эрхтэй.” гэж, арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус тодорхойлсон.

Гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөнд ноцтой заналхийлэл учруулдаг бөгөөд түүнээс урьдчилан сэргийлэх ажил нь аливаа улсын хууль сахиулах тогтолцооны үндсэн чиг үүрэгт багтдаг. Монгол Улсад прокурорын байгууллага нь зөвхөн эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх төдийгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаанд онцгой байр суурь эзэлж ирсэн.

Онцлон дурдвал МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1972 оны 96 дугаар тогтоолоор БНМАУ-ын прокурорын газрын дэргэд Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг байгуулах тухай шийдвэр гаргасан. Уг шийдвэрийн дагуу БНМАУ-ын прокурорын 1973 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 38 дугаар тушаалаар Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг 1973 оны 3 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан байна.

Тус хүрээлэн нь 1973-1983 оны хооронд үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд БНМАУ-ын Прокурорын Газрын системд багтаж, Монгол улсад гарч

байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах эрдэм шинжилгээний байгууллага байв. Тус хүрээлэнгээс хийсэн судалгааны дүн, эрдмийн бүтээлд үндэслэн эрдэм шинжилгээний ном 10 гаруйг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, хууль хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгоход чиглэсэн эрдэм шинжилгээний зөвлөмж 50 гаруй, эрдэм шинжилгээний өгүүлэл 80 гаруйг бичиж нийтлүүлсэн байна. Түүнчлэн 1974 оноос эхлэн "Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал" гэсэн эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг жил тутам гаргаж 8 дугаарыг хэвлүүлсэн байна. Мөн тус хүрээлэнгээс "Хууль ёс" сэтгүүлийг 1973 оноос эхлэн эрхлэн гаргасан бөгөөд 1991 он хүртэл нийт 89 дугаар хэвлэгдэн гарч олны хүртээл болсон байна.

Прокурорын байгууллагаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэж байгаа ажил, арга хэмжээг дараах байдлаар тодорхойлж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр прокурорын чиг үүрэг:

Монгол улсын Эрүүгийн хууль тогтоомж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад эрх зүйн баримтад дурдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр Улсын Ерөнхий прокурорын тушаалаар холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг батлан гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журам"-ыг 2019 онд батлан гаргаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Прокурорын байгууллагаас баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж байна.

Энэхүү журмаар зөвлөл нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөнд санал өгөх, төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг хангах, Прокурорын байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулах, хийсэн ажлын тайланг бүтэн жилээр тооцон дүгнэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх статистик мэдээг нэгтгэн судалж, дүгнэлт хийх, нэгж прокурорын газруудыг мэргэжил арга зүйгээр хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох суурь болон хавсарга судалгаа хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Түүнчлэн анхан шатны нэгжийн прокурорын газрын ерөнхий прокурор нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцан ажиллахаар заасан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг прокурорын

үндсэн хяналтын ажлын адил ач холбогдол өгч, анхаарч ажиллах нөхцөл бүрдсэн.

2. “Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах аргачлал”-ыг 2020 онд батлан гаргасан.

Энэхүү аргачлалаар, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг судлах арга зүйг тогтооход анхаарах асуудал болох судалгааны зорилго, төлөвлөлт, удирдамжийг боловсруулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг судалгааны үе шатыг тодорхой болгож өгсөн.

3. “Прокурор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар”-ыг 2021 онд батлан гаргасан.

Энэхүү зааврааp Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд нийт прокуроруд хяналтын ажлын чиглэл харгалзахгүй жигд оролцож, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тодорхойлсон зорилго, зарчим, үндсэн чиглэлийн дагуу эрхэлсэн асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх талаар зааж, прокурорын оролцооны хэлбэрийг тодорхойлсон.

Тухайлбал прокурор нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхдээ мэдэгдэл бичих, дангаараа болон бусад байгууллагатай хамтран шалгалт хийх, яриа таниулга, сургалт, сурталчилгаа хийх, мэдээ, мэдээлэл бэлтгэн хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр түгээх, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр суурь болон хавсарга судалгаа хийх зэргээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцохоор заасан.

4. “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журам”-ыг 2020 батлан гаргаж, Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээ хязгаарыг тодорхойлсон.

Энэхүү журамд Зөвлөл нь зөрчил шалган шийдвэрлэх, эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон ял эдлүүлэх ажиллагааны явцад хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажлыг прокурорын байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулахаар заасан.

5. “Сургалтын гарын авлагад тавигдах стандарт”-ыг 2021 онд баталснаар прокурорын байгууллагаас зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, катологид үндэслэн сургалтад ашиглагдах гарын авлагыг нэгдсэн жишиг бүхий, ижил шаардлагын дагуу боловсруулах үйл явцыг зохицуулсан.

6. “Судалгаа хийх аргачлал”-ыг 2023 онд баталснаар Прокурорын байгууллагаас шинжлэх ухааны болон хяналтын ажлын судалгаа хийх арга зүйг нэг мөр хэрэгжүүлэх, судалгааны чанар, үр нөлөөг сайжруулахад ахиц гарч энэ хирээр гэмт хэрэг зөрчилд дүн шинжилгээ хийх, улмаар урьдчилан сэргийлэх ажлыг илүү академик түвшинд зохион байгуулах боломж бүрдээд байна.

Энэ аргачлалд судалгаа хийхтэй холбоотой бүх асуудлыг тусгаснаас гадна Прокурорын байгууллагаас судалгааны талаар баримтлах үзэл баримтлалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5 жилийн төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар батлагдсан дээрх эрх зүйн баримт бичгүүдээс гадна прокурорын хяналтын ажлын чиглэлээр гаргасан бусад заавар, журамд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг тодорхой байдлаар тусгасан байдаг.

Түүнчлэн эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжид шинээр орсон өөрчлөлт болон УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор прокурорын байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд шинэчлэлийг цаг тухай бүрт нь хийж ирсэн.

Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаартай тогтоолыг үндэслэн Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын хамтын нийгэмлэг (GIZ), “Ай Ти Зон” ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г бий болгох, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг 2022 оноос үе шаттай хэрэгжүүлж байна. Үүнд:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2025-07-09-ний өдрийн хуульд “Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, харилцан мэдээлэл солилцох зорилго бүхий зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сантай байх” зохицуулалт албан ёсоор тусгагдаж, хууль эрх зүйн хувьд ашиглах боломж бүрдсэн.

Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг улсын хэмжээнд ажиллаж байгаа зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 65 чиг үүргийн 1,102 байгууллагын 13,000 орчим эрх бүхий албан тушаалтнууд өдөр тутамдаа хэрэглэж, Зөрчлийн хууль тогтоомж энэ системээр дамжин хэрэгжиж байна.

Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан хэрэглээнд нэвтэрснээр интернэт холбогдсон аль ч газраас гомдол, мэдээлэл, зөрчлийн хэрэг, шийдвэрийг бүртгэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа шуурхай явагдах нөхцөлийг бүрдүүлээд байна.

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан, прокурор нь нэгдсэн системээс түүнд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн боловсруулагдсан эрх зүйн хэлбэр, мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа удирдамжийн баримт бичгүүдийг файлаар татан авч ашиглахаас гадна шаардлагатай мэдээ, судалгаа, хяналт шинжилгээ хийсэн статистик тоон үзүүлэлтийг чиглэл тус бүрээр гарган авч байна.

Цаашид Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг хэрэглээнд нэвтрүүлснээр зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, түүнд тавьж буй прокурорын хяналтын ажилд томоохон ахиц дэвшил гарч, байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо сайжирч, Монгол улсын хэмжээнд зөрчлийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх ажилд ихээхэн их хувь нэмэр оруулна.

Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст Авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан албыг 2024 онд байгуулснаар Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр" зэрэг болон энэ төрлийн гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэх, нэгдсэн дүн шинжилгээ хийх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ авч, хэрэгжүүлж байна.

Улсын ерөнхий прокурорын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/48 дугаар тушаалаар "Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн"-г шинэчлэн байгуулж, УИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар тус хүрээлэнгийн эрх зүйн үндсийг баталгаажуулж 118 дугаартай тогтоол гаргасан. Энэхүү шийдвэр нь прокурорын байгууллагын хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах, прокурорын байгууллагын өмнө тулгамдаж буй асуудал, хууль хэрэглээний чиглэлээр суурь болон хавсарга судалгааг дангаар болон бусад байгууллагатай хамтран хийх зэргээр сургалт, судалгааны чиглэлээр зохих дэвшил гарах, тус хүрээлэнгийн үйл ажиллагаа нь байнгын, тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн түүхэн шийдвэр болсон.

Тус хүрээлэн нь 15 орчим дэд сэдвээр суурь болон бодлогын судалгаа хийж, эрдэм шинжилгээний ном 10, эрдэм шинжилгээний зөвлөмж 50, эрдэм шинжилгээний өгүүлэл 80 гаруйг бичиж нийтлүүлээд байна. Мөн "Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал" нэртэй эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг жил бүр хэвлүүлж, өнөөг хүртэл 8 дугаарыг олон нийтэд хүргэсэн байна.

Монгол улсын эрүүгийн хууль тогтоомж, Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар батлагдсан дээрх эрх зүйн баримт бичгийн дагуу хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчигдөхөөс сэргийлэх

үүргээ хэрэгжүүлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дараах хэлбэрээр тогтмол оролцож байна. Үүнд 2021-2024 онуудад:

Гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зорилгоор прокурорын мэдэгдэл нийт 6890 бичиж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн, мэдэгдлийн мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний хариуг авч, биелэлтийг тооцож ажилласан.

Прокурорын байгууллага дангаар болон бусад байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн биелэлтийг байгууллага, аж ахуйн нэгжид 1031 шалгаж, оролцсон.

Хяналтын ажлын тоон мэдээ, шалгалт, судалгааны дүн болон Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах яриа таниулгыг олон нийтэд 2510 удаа хийсэн.

Эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, зөвлөгөөнийг байгууллага, олон нийтэд 749 удаа зохион байгуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021-2024 онд хэлэлцүүлэг 72 удаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ 694, гарын авлага 458 гарын авлагыг бэлтгэж олон нийтэд хүргэсэн.

Мөн 2021-2023 онд 87 подкаст, 79 шторк, 350 контент, 534 постер, инфографик, 48 ярилцлага, 51 нийтлэл, нэвтрүүлгийн бэлдэж олон нийтэд хүргэсэн бол Байгууллагын цаг үеийн үйл явдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сар бүр “Прокурорын мэдээлэл” нэвтрүүлгийг бэлтгэж МҮОНРТ-ээр гаргаж, 12 удаагийн, 240 минутын нэвтрүүлгийг жил бүр олон нийтэд хүргэдэг болоод байна.

Прокурорын байгууллага нь гэмт хэрэг, зөрчлийн гаралт, түүний шалтгаан нөхцөлийг улсын болон орон нутгийн хэмжээнд судлах чиглэлд онцгой анхаарч суурь болон хавсарга судалгааг тогтмол хийж байна. Тухайлбал 2021 онд 244, 2022 онд 260, 2023 онд 233, 2024 онд 200 удаагийн судалгааг нэгдсэн байдлаар болон тухайн нэгж Прокурорын газрын хэмжээнд хийсэн байна.

Түүнчлэн дээрх судалгааны дүнд үндэслэн болон эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхэд анхаарч судлаач, эрдэмтэд, эрх зүйн чиглэлээр суралцаж байгаа оюутан, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч, хууль сахиулах байгууллагуудын албан хаагч нар болон прокуроруудыг хамруулсан эрдэм шинжилгээний илтгэл, хэлэлцүүлэг зэргийг тогтмол зохион байгуулахаас гадна бусад байгууллагаас зохион байгуулж байгаа хэлэлцүүлэг, илтгэл прокурорын байгууллагын албан хаагч нарыг оролцуулах зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Мөн Улсын ерөнхий прокурорын газраас “Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2024 онд, “Олон Улсын Прокуроруудын Холбооны Зүүн Европ, Төв Азийн бүсийн 10 дугаар бага хурал”-ыг 2025 онд тус тус зохион байгуулсан нь дотоод, гадаадын эрдэмтэн судлаачид болон хуулийн байгууллагын албан хаагч нар хуран цуглаж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, олон улсын сайн туршлага, мэдээллийг харилцан солилцож, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлэн, нийтийн хүртээл болгоход чиглэгдсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Монгол Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар батлагдсан эрх зүйн баримт бичгүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг тодорхой тусгаснаар прокуророос гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох оролцоо илүү үр дүнтэй болж, прокурорын байгууллагын хяналтын ажлын нэг хэсэг болсон.

Прокурорын байгууллага зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрх бүхий байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлж, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн уялдаа сайжирсан нь урьдчилан сэргийлэх бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй болгоход эерэг нөлөө үзүүлэв.

Улсын ерөнхий прокурорын газар улсын хэмжээнд зөрчлийн статистикийн үйл ажиллагаа эрхэлж, түүний нэгдмэл байдлыг хангаж ажиллах нөхцөл бүрдсэнээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх төрийн бодлого, Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг тодорхойлох болсон.

Прокурорын байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор О.Алтангэрэл

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцох прокурорын байр суурь

- Монгол улсын үндсэн хууль
- Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомж
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль

Монгол Улсын Үндсэн хууль

- Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг: Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.
- Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтад: “эрүүл, аюулгүй орчинд амьдрах,… эрхтэй.”
- Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”

МАХН -ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1972 оны 96 дугаар тогтоол

БНМАУ -ын прокурорын газрын дэргэд Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг байгуулах тухай шийдвэр гаргасан.

БНМАУ-ын прокурорын 1973 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 38 дугаар тушаал

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг 1973 оны 3 дугаар сарын 1-ний өдөр байгуулсан

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэн

1973-1983

- Эрдэм шинжилгээний ном 10 гаруйг
- Эрдэм шинжилгээний зөвлөмж 50 гаруй, Эрдэм шинжилгээний өгүүлэл 80 гаруйг
- “Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэлийг жил тутам гаргаж 8 дугаар
- “Хууль ёс” сэтгүүлийг 1973 оноос эхлэн эрхлэн гаргасан бөгөөд 1991 он хүртэл нийт 89 дугаар

Монгол Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар батлагдсан Эрх зүйн баримт бичгүүд

- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журам” 2019 он
- “Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах аргачлал” 2020 он
- “Прокурор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар” 2021 он
- “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журам” 2020
- “Сургалтын гарын авлагад тавигдах стандарт” 2021 он
- “Судалгаа хийх аргачлал” 2023 он

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журам”

Энэхүү журмаар зөвлөл нь

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, салбар зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөнд санал өгөх, төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийг хангах
- Прокурорын байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулах, хийсэн ажлын тайланг бүтэн жилээр тооцон дүгнэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх статистик мэдээг нэгтгэн судалж, дүгнэлт хийх
- Нэгж прокурорын газруудыг мэргэжил арга зүйгээр хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоох сууль болон хавсрага судалгаа хийх
- Түүнчлэн анхан шатны нэгжийн прокурорын газрын ерөнхий прокурор нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцан ажиллахаар заасан

“Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлах аргачлал”

Судалгаанд анхаарах асуудал

- Судалгааны зорилго, төлөвлөлт, удирдамжийг боловсруулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг судалгааны үе шатыг тодорхой болгож өгсөн

“Прокурор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар”

Прокурорын оролцоо

-Нийт прокуроруд хяналтын ажлын чиглэл харгалзахгүй жигд оролцоо,

-Хуулийн зорилго, зарчим, үндсэн чиглэлийн дагуу эрхэлсэн асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх

-Прокурорын оролцооны хэлбэрийг тодорхойлсон:

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхдээ мэдэгдэл бичих,

-Дангаараа болон бусад байгууллагатай хамтран шалгалт хийх, яриа таниулга, сургалт, с урталчилгаа хийх, мэдээ, мэдээлэл бэлтгэн хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр түгээх,

-Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж бүй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр сүүрь болон хавсарга судалгаа хийх

“Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журам”

Зөвлөлийн чиг үүрэг

Зөвлөл нь зөрчил шалган шийдвэрлэх, эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон ял эдлүүлэх ажиллагааны явцад хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүү шүүлт түлгах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажлыг прокурорын байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулахаар заасан.

“Сургалтын гарын авлагад тавигдах стандарт”

Прокурорын байгууллагаас зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, катологид үндэслэн сургалтад ашиглагдах гарын авлагыг нэгдсэн жишиг бүхий, ижил шаардлагын дагуу боловсруулах үйл явцыг зохицуулсан.

Гарын авлагын бүтэц:

-оршил;
-сэдвийн хүрээг тодорхойлсон онолын үндсэн ойлголт;
-тухайн сэдвийг гүнзгийрүүлэн судлахад шаардлагатай заавал уншиж судлах эх зохиол, сурах бичиг, ном, сэтгүүл, шүүхийн шийдвэр, цахим хэрэглэгдэхүүнийг сэдэв бүрийн агуулгад нийцүүлэн нарийвчлан заасан жагсаалт;
-ашигласан материалын жагсаалтж авсан мэдлэгийг үнэлэх, бататгах сорил;
-хавсралт.

Гарын авлага нь агуулга болон хэлбэрийн хувьд “Эрдэм шинжилгээний ажлын тайлан, бүтэц, шаардлага” MNS2492:2004 Монгол Улсын стандартын нийтлэг шаардлагын дагуу боловсруулагдсан

“Судалгаа хийх аргачлал”

Прокурорын байгууллагаас шинжлэх ухааны болон хяналтын ажлын судалгаа хийх арга зүйг нэг мөр хэрэгжүүлэх, судалгааны чанар, үр нөлөөг сайжруулахад ахиц гарч энэ хирээр гэмт хэрэг зөрчилд дүн шинжилгээ хийх, улмаар урьдчилан сэргийлэх ажлыг илүү академик түвшинд зохион байгуулах боломж бүрдээд байна

Судалгаа хийхэд тоон болон чанарын судалгааны арга зүйгээр нийгмийн шинжлэх ухааны нийтлэг болон тусгай аргуудыг ашиглаж байна

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Улсын Ерөнхий Прокурорын Газар улсын хэмжээнд зөрчлийн статистикийн үйл ажиллагаа эрхэлж, түүний нэгдмэл байдлыг хангана.

Гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого боловсруулах иргэнд шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор гэмт хэрэг, зөрчлийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглана.

“Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”

Улсын ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын хамтын нийгэмлэг (GIZ), “Ай Ти Зон” ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г бий болгох, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг 2022 оноос үе шаттай хэрэгжүүлж байна.

“Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 65 чиг үүргийн 1,102 байгууллагын 13,000 орчим эрх бүхий албан тушаалтны болон зөрчлийн хэргийн мэдээлэл

Интернэт холбогдсон аль ч газраас гомдол, мэдээлэл, зөрчлийн хэрэг, шийдвэрийг бүртгэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа шуурхай явагдах нөхцөл бүрдсэн.

Эрх зүйн хэлбэр, удирдамжийн баримт бичгүүдийг файлаар татан авч ашиглахаас гадна шаардлагатай мэдээ, судалгаа, хяналт шинжилгээ хийсэн статистик тоон үзүүлэлтийг чиглэл тус бүрээр гаргах боломжтой.

Улсын ерөнхий прокурорын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/48 дугаар тушаал

УИХ-ын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар тус хүрээлэнгийн эрх зүйн үндэсийг баталгаажуулж 118 дугаартай тогтоол гаргасан

Энэхүү шийдвэр нь прокурорын байгууллагын хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах, прокурорын байгууллагын өмнө тулгамдаж буй асуудал, хууль хэрэглээний чиглэлээр суурь болон хавсарга судалгааг дангаар болон бусад байгууллагатай хамтран хийх зэргээр сургалт, судалгааны чиглэлээр зохих дэвшил гарах, тус хүрээлэнгийн үйл ажиллагаа нь байнгын, тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн түүхэн шийдвэр болсон.

Авлига, м өнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх алба



Улсын ерөнхий прокурорын 2024 оны А/58 дугаартай тушаалаар Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст “Авлига, мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх алба”-ыг байгуулсан.

Улсын ер өнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны х үрээлэн

- 15 орчим дэд сэдвээр суурь болон бодлогын судалгаа
- Эрдэм шинжилгээний ном 10
- Эрдэм шинжилгээний зөвлөмж 50
- Эрдэм шинжилгээний өгүүлэл 80
- “Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” нэртэй эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлийг жил бүр хэвлүүлж, өнөөг хүртэл 8 дугаарыг олон нийтэд хүргэсэн байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дараах хэлбэрээр тогтмол оролцож байна. Үүнд: 2021-2024

Прокурорын мэдэгдэл нийт 6890 бичиж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн, мэдэгдлийн мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний хариуг авч, биелэлтийг тооцож ажилласан

Прокурорын байгууллага дангаар болон бусад байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн биелэлтийг байгууллага, аж ахуйн нэгжид 1031 шалгаж, оролцсон

Хяналтын ажлын тоон мэдээ, шалгалт, судалгааны дүн болон Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах яриа таниулагыг олон нийтэд 2510 удаа хийсэн.

Эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, зөвлөгөөнийг байгууллага, олон нийтэд 749 удаа зохион байгуулсан

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2021-2024 онд хэлэлцүүлэг 72 удаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ 694, гарын авлага 458 гарын авлагыг бэлтгэж олон нийтэд хүргэсэн.

Мөн 2021 -2023 онд

87 подкаст,
79 шторк,
350 контент,
534 постер, инфографик,
48 ярилцлага,
51 нийтлэл, нэвтрүүлгийн бэлдэж олон нийтэд хүргэсэн.

Байгууллагын цаг үеийн үйл явдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сар бүр "Прокурорын мэдээлэл" нэвтрүүлгийг бэлтгэж MYOHPT-ээр гаргаж, 12 удаагийн, 240 минутын нэвтрүүлгийг жил бүр олон нийтэд хүргэдэг болоод байна.

УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН СУДАЛГАА

- 2021 онд 244
- 2020 онд 260
- 2023 онд 233
- 2024 онд 200

2024 “Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал

2025 “Олон Улсын Прокуроруудын Холбооны Зүүн Европ, Төв Азийн бүсийн 10 дугаар бага хурал”

Дүгнэлт

- Монгол Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар батлагдсан эрх зүйн баримт бичгүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг тодорхой тусгаснаар прокуророос гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд оролцох оролцоо илүү үр дүнтэй болж, прокурорын байгууллагын хяналтын ажлын нэг хэсэг болсон.
- Прокурорын байгууллага зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эрх бүхий байгууллагуудад үе шаттайгаар нэвтрүүлж, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн уялдаа сайжирсан нь урьдчилан сэргийлэх бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй болгоход эерэг нөлөө үзүүлэв.
- Улсын ерөнхий прокурорын газар улсын хэмжээнд зөрчлийн статистикийн үйл ажиллагаа эрхэлж, түүний нэгдмэл байдлыг хангаж ажиллах нөхцөл бүрдснээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх төрийн бодлого, Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын бодлогыг тодорхойлох болсон.

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖЛЫН ҮР ДҮН

Х.ИХМӨРӨН
Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар

Юуны өмнө Та бүхэндээ Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл үүсгэн байгуулагдсаны 60 жилийн ойн мэндийг хүргэж, уулзалт хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэр тусмаа тодорхой гэмт хэрэг болох авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх хүрээнд Авлигатай тэмцэх газраас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж ирсэн талаар та бүхэнд мэдээлэл өгөх болсонтой баяртай байна.

Бид авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, түүнийг арилгах, таслан зогсоох үйл ажиллагаа, нөгөө талаас олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, энэ үйл ажиллагаанд тэдгээрийг татан оролцуулахад чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, арга зүйн удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Төрийн байгууллагын аль нэг салбар, байгууллагад авлигын, албан тушаалын гэмт хэрэг яагаад гарах болов?, шалтгаан нөхцөл нь юунд байна? гэдгийг судлан үзсэний үндсэн дээр тэдгээр салбар, байгууллагын нөхцөл байдал, авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх тохирсон ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарч ажилладаг билээ. Тухайлбал, авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хүчингүй болгуулах, Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, аймаг, нийслэл, сум дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг чиглэл өгөх, төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй санал, санаачилгыг дэмжих туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх, авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар Зөвлөмж гаргах, авлигад өртөх боломжийг багасгах, эрсдэлийг арилгах, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэн ажилладаг.

Харин соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд авлигын хор аюулыг ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулж, авлигын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, авлигатай тэмцэх арга барилд сургахад чиглэсэн сургалт, мэдээлэл хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх, сурталчилгааны материал түгээх зэргээр ажиллаж байна. Мөн тодорхой хүрээ, салбар, зорилтот бүлэгт

чиглэсэн тусгайлан арга хэмжээ, кампант ажил, аяныг зохион байгуулж, энэхүү үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг татан оролцуулж ирсэн ба эдгээр үйл ажиллагааг аль болох олон нийтэд сонирхолтой байдлаар, технологийн дэвшлийг ашиглах замаар, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг юм.

Сүүлийн жилүүдэд бид богино хэмжээний шторк, видео контент, жүжигчилсэн тоглолт, кино контентоор дамжуулан авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэхэд анхааран ажиллаж байгаа бөгөөд тодорхой үр дүн хүрсэн, амжилттай хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээнээс цөөхнийг дурдвал,

1. Өнгөрсөн жил бид авлигын бодит хэргээс сэдэвлэн бүтээсэн “Зура 3-Цэвэрлэгээ” уран сайхны киног бүтээхэд Фантастик продакшнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллалаа. Энэхүү бүтээлийг кино театрт нийт 66,939 хүн үзэж, рекорд эвдсэн талаарх судалгаа гарсан байсан төдийгүй бид кино урлагаар дамжуулан авлигын хор хөнөөл, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаа, албан хаагч нарт тулгамддаг асуудлуудыг иргэдэд ойлгуулж чадсан.

2. Манай улсад авлигын гэмт хэрэг, зөрчлөөс гадна төрийн албаны хунд суртал, чирэгдэл иргэн, аж ахуйн нэгж буюу төрөөс үйлчилгээ авч буй этгээдүүдэд тулгамдсан асуудлуудын нэг нь мэдээлэл ил тод бус, тодорхойгүй байдагтай холбоотой байдаг. Бид энэ чиглэлээр Цахим хөгжил, харилцаа холбооны яам, "Е-Монгол" академитай хамтран ажилласан зохих үр дүнгээ өгч эхэллээ. Өнөөдрийн байдлаар төрийн 1200 үйлчилгээг цахим хэлбэрт шилжиж, энэ нь төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгахад чухал хөшүүрэг болсон нь эерэг үр дүн юм. Одоогийн байдлаар E-Mongolia 5.0 системийн бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 1,962,844-д хүрч, иргэдээс төрийн үйлчилгээ авахад зарцуулдаг зардалд 1,323,483,322,829 төгрөгийн бодит хэмнэлт бий болсон.

Түүнчлэн Авто тээврийн үндэсний төвийн цахим систем болон Татварын удирдлагын нэгдсэн систем хооронд мэдээлэл солилцох хурд нэмэгдэж, систем хөгжүүлэлтийг ажлыг тогтмол хийж байна. Үр дүн нь иргэдийн мэдээлэл зөрдөг асуудал шийдэгдэж, өөрийн биеэр очих шаардлагагүйгээр мэдээлэл засварлах боломжтой болсон нь цаг хугацаа хэмнэсэн, зохиомол ачааллыг арилгахад үр дүнгээ өгч байна.

3. Жил бүр хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан элсэлт бүртгэлийн үйл ажиллагаанд гардаг сөрөг үр дагаврууд багасаж байна. Өмнө нь тойргийн бус хүүхэд сургуульд элсүүлэх, эцэх эхчүүд заавал сургуульд очиж оочир дараалал үүсгэх асуудлууд түгээмэл байсныг арилгаж, сургууль, цэцэрлэгийн бүртгэл 100 хувь цахим хэлбэрт шилжээд дариу 5 жил болж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг

жил бүр ажилладаг ба давхардсан тоогоор 250 гаруй сургууль, цэцэрлэгийн элсэлт, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ирсэн.

4. Авлигын эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын сангуудын үйл ажиллагаанд авлигын эрсдэлийн үнэлгээ хийх, тусгайлан баталсан удирдамжийн дагуу газар дээр нь ажиллаж, илэрсэн зөрчил дутаг, нөхцөл байдалд тулгуулан Зөвлөмж өгч, түүний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. тухайлбал, Өнгөрсөн жил бид "Кино урлагийг дэмжих сан", "Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан", "Эрүүл мэндийг дэмжих сан", "Бүх нийтийн үүргийн сан", "Шинжлэх ухаан, технологийн сан", "Нийгмийн даатгалын сан", "Боловсролын зээлийн сан"-д ажилласан бол энэ жилийн тухай Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд ажиллаж авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Зөвхөн энэ онд гэхэд төрийн 96 байгууллагад үйлчлүүлэгч иргэдийн хувиар тандалт ажиглалт хийж, төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдлийг илрүүлэн тогтоож, арилгахад чиглэсэн ажлыг гүйцэтгэлээ.

5. Өмнө нь авлигын гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэхэд голлон анхаарч ажилладаг байсан бол сүүлийн 3 жилийн хугацаанд авлигын гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, тодорхой тооны хөрөнгийг эрсдэлд оруулахаас хамгаалж чаддаг болсон. Тухайлбал, Засгийн газрын "Хүүхдийн төлөө сан"-д "Хүүхдийн төлөө фонд"-д байсан хөрөнгийг нэгтгэж, Авто тээврийн хэрэгслийн "Аз"-ын гэх тодотголтой улсын дугааруудыг дуудлага худалдаанд оруулах чиглэлээр ажиллаж, төвлөрсөн хөрөнгийг хүүхдийн төлөө санд төвлөрүүлж чадсан. Тодруулбал, 26 орчим тэрбум төгрөгийн орлого тус санд төвлөрсөн. Энэ нь тодорхой албан тушаалтнаас азын гэх тодотголтой дугаарыг бусдад давуу байдал үүсгэн борлуулдаг, худалдан борлуулсны төлбөр хэн нэгэн албан тушаалтны халаасанд ордог байсныг таслан зогсоож, өдгөө улсын төсөвт төвлөрдөг болсон.

6. Түүнчлэн нийслэлээс зохион байгуулж буй мега төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гардаг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 17 мега төсөл, тэд бүтцийн салбарын барилга, эрчим хүч, зам тээвэр салбар, орон нутагт хэрэгжүүлж буй бусад 32 төсөл, хөтөлбөрийн нэгжтэй уулзаж, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж байна.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, хамтарсан хэрэг шалган шийдвэрлэх, алдагдсан хөрөнгийг буцаан авах ажлын хүрээнд гадаад хамтын ажиллагаа харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгойлон анхаарч БНХАУ, БНСУ, Бүгд Найрамдах Азербайжан улс, Бүгд Найрамдах Казакстан улс, Малайз улс, Тайландын Хаант улсын Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулан, идэвхтэй хамтран ажиллаж байна.

Дөрөвхөн жилийн өмнө гадаад улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүйн улмаас бид гадагш алдсан хөрөнгө болон иргэнийг өөрийн улсад буцаан авах боломжгүй байсан. Сүүлийн жилүүдэд гадаад улс, олон улсын байгууллагатай идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлж, энэ хүрээнд авлигын гэмт хэргийн улмаас учирсан 13,9 сая доллар буюу 50 гаруй тэрбум төгрөгийн хохирлыг гадаад улс орнуудаас татан авч, улсыг хохиролгүй болгох ажлыг зохион байгууллаа. Энэ нь зөвхөн гадаад улс орноос хохирол нөхөн төлүүлэхээр татан авсан мөнгөн дүн. Сүүлийн 4 жилийн байдлаар гадаад болон дотоод үйлдэгдсэн авлигын гэмт хэргийг шалгаж нийт 3,2 их наяд төгрөгийн хохирлыг улсад нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулжээ.

Бид цаашид авлигатай тэмцэх, авлигын гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ;
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зүр дүн, үр нөлөөг үнэлэх арга зүйг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлнэ;
- Амьдралын хэв маяг, үзэл бодол, үнэт зүйлс, соёлд тулгуурлан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, үр нөлөөг нэмэгдүүлнэ;
- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэд технологи цахим платформыг судалж, нэвтрүүлнэ;
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөлийг судлах, эрсдэл тодорхойлох, хяналт тавих ажлыг иргэний нийгэм, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, оролцоог нэмэгдүүлнэ;
- Үндэсний контентыг бүтээж, авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлнэ;
- Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ;
- Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг олон улсын туршлага, үндэсний онцлогт нийцүүлэн тусгаж, дүн шинжилгээ хийж, үр нөлөөг үнэлнэ;
- Эрсдэлд суурилсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна;
- Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна;

• Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоно;

• Хүүхдийн шударга байдалд мөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

• Боловсролын сургалтын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээг зохион байгуулж хэвшинэ;

• Сонгогчийн боловсрол, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын сүлжээ үүсгэн, хамтын ажиллагааг өргөжүүлж, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлнэ;

• Ирээдүйд тулгарч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх аргачлалыг боловсруулж, бэлэн байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

2025

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

6 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

e mongolia
Цахим үндэстэн

ХҮНД СУРТАЛГҮЙ ЦАХИМ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “Е-Монгол” академитай хамтран 2017 оноос хойш төрийн 1200 үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, төрийн үйлчилгээний хүнд суртал чирэгдлийг арилгав. Одоогийн байдлаар E-Mongolia 5.0 системийн бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 1,962,844 байна. Дээрх цахим үйлчилгээг үзүүлснээр иргэд төрийн үйлчилгээ авахад зарцуулдаг зардал зэрэг нийт 1,323,483,322,829 төгрөгийн бодит хэмнэлт бий болж төрийн үйлчилгээний хүнд суртал, хүлээлгэ багассан эерэг үр дүн үзүүлж байна.

1 Иргэдэд эмнэлэгт цаг авах үйлчилгээг авахад цахим хэлбэрээр цаг авсан иргэд болон тухайн эмнэлэг дээр ирж үйлчилгээ авч байгаа иргэдийн дунд үл ойлголцдог байсныг эмнэлэг тус бүрийн цахим систем болон И-Монгол цахим үйлчилгээний систем хоорондын уялдаа хангагдсан.

2 Авто тээврийн үндэсний төвийн цахим болон Татварын удирдлагын нэгдсэн систем хооронд мэдээлэл солилцох хурд нэмэгдэж, систем хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. Үр дүнд нь иргэдийн мэдээлэл зөрдөг асуудал шийдэгдэж. Өөрийн биеэр очих шаардлагагүйгээр мэдээлэл засварлах боломжтой болсон.

НЭГДЭЭ
Үгүй гэж хэлээд өөрчилье! 110

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

АЖЛЫН ХЭСЭГ-2024 ОНД	ТАНДАЛТ-2025 ОНЫ ХАГАС ЖИЛД:
Засгийн газрын 7 тусгай сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав. • Кино урлагийг дэмжих сан; • Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан; • Эрүүл мэндийг дэмжих сан; • Эрүүл мэндийн даатгалын сан; • Бүх нийтийн үүргийн сан; • Шинжлэх ухаан, технологийн сан; • Нийгмийн даатгалын сан болон Хөдөө аж ахуйн корпорац ТӨХХК;	Салбар бүрд чиглэсэн 96 байгууллагад тандалтаар ажиллав.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЭЛСЭЛТ БҮРТГЭЛ

Хичээлийн жилийн элсэлт, бүртгэлийн үйл ажиллагаанд өмнө гардаг байсан тойргийн бус хүүхэд сургуульд элсүүлэх оролдлого, төрийн байгууллага, албан тушаалтнаас ирдэг дарамт, шахалт, нөлөөлөл багасаж, иргэд олон нийтийн оролцоо, хяналт сайжирч авлигын эрсдэл гаргах явдал тодорхой хэмжээнд буурсан.

АТГ сүүлийн 10 жилийн байдлаар жил бүр ажлын хэсэг ажиллаж, давхардсан тоогоор 250 гаруй сургууль, цэцэрлэгийн элсэлт, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ирсэн.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САН
БОЛОН БУСАД СУРГАЛТЫН ТӨСӨВ



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

АЗЫН ГЭХ ТОДОТГОЛТОЙ УЛСЫН ДУГААРУУДЫГ ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРУУЛСНААР 26,0 ОРЧИМ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ ТУСГАЙ САНД ТӨВЛӨРҮҮЛЖЭЭ

Автомашины азын гэх тодотголтой дугаарыг бусдад давуу байдал үүсгэн борлуулдаг тохиолдол их байсан бөгөөд хэн нэгэн албан тушаалтны халаасанд ордог мөнгө өдгөө улсын төсөвт төвлөрдөг болсон. Учир нь автомашины азын 3000 гаруй дугаарыг бусдад давуу байдал үзүүлж олгосон АТҮТ-ийн зарим албан тушаалтнуудыг Авлигатай тэмцэх газраас шалгаж, хариуцлага тооцсон.

Зам тээврийн яаманд Авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах хүрээнд АТГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсээс хоёр удаагийн зөвлөмж өгч, журам шинэчлэх ажлын хэсгийн гурван удаагийн хурал, тухайн үеийн салбарын сайдтай хоёр удаагийн уулзалт зохион байгуулж байжээ. Үүний үр дүнд авлигын шалтгаан бүхий журам өөрчлөгдөж, одоо автомашины азын дугаарыг үнэ хаялцуулах ажил хийгдэх болсон юм.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нийт 502 төсөл, арга хэмжээнээс Барилга угсралтын ажил удаашралтай зогссон болон асуудалтай 51 барилга байгууламж байв. 17 барилга байгууламжийн асуудлыг АТГ шийдвэрлэсэн. 2025 оны байдлаар 34 барилга байгууламж байна.

1. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам - 9 ажил;
2. Боловсролын яам - 25 ажил;
3. Эрүүл мэндийн яам - 4 ажил;
4. Биеийн тамир, спортын улсын хороо - 2 ажил;
5. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам - 5 ажил;
6. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам - 3 ажил;
7. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам - 1 ажил;
8. Азийн хөгжлийн банк - 1 ажил;
9.Бусад - 1 ажил. */Өмнөговь аймгийн ГХБХБГ-т эрх шилжсэн./*

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

- Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй 17 мега төсөл;
- Дэд бүтцийн салбарын барилга, эрчим хөгжил, зам тээвэр, орон нутаг, эдийн засгийн салбар

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

ЦЭРЭГ ТАТЛАГА

- Хөндлөнгийн хяналт тавих;
- Ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх;

КОМИСС АРГА ХЭМЖЭЭ

- Сэлгүүлэн ажиллуулсан
- Журмыг хянаж өөрчлөлт оруулах санал хүргүүлсэн
- Зөвлөмж хүргүүлсэн
- Үндэслэлгүй хөрөнгөжих эрсдэлээс урьдчилан сэргийлсэн

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соёл гэгээрүүлэх хэлтэс

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

IACA · OECD · UNODC · ARIN-AP · ADB Asian Development Bank · INTERPOL · Transparency International · OSCE Organization for Security and Co-operation in Europe · STAR Stolen Asset Recovery Initiative The World Bank • UNODC · IAACA International Association of Anti-Corruption Authorities · GLOBE Network · Egmont Group · FATF · Criminal Division U.S. Department of Justice · AFP · NCA National Crime Agency

САНАМЖ БИЧИГ

The World Bank · ICAC · IDLO · HKIARC Hong Kong International Academy against Corruption · The Anti-Corruption Agency of the Republic of Uzbekistan · Anti-Corruption & Civil Rights Commission · IACA International Anti-Corruption Academy · Basel Institute on Governance · IACCC International Anti-Corruption Coordination Centre

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соёл гэгээрүүлэх хэлтэс

ХУУЛЬ БУС ХӨРӨНГӨ БУЦААСАН САЙН ТУРШЛАГА


United Nations | Office on Drugs and Crime

The Mongolian orphanage benefiting from international asset recovery

UNODC
Children showing off the vegetables they grew at the orphanage's greenhouse.

International conventions and treaties can often feel distant, complex and removed from everyday life—important for politicians and lawyers, perhaps, but unrelated to the lives of ordinary people.

However, a recent case in Mongolia highlights how the UN Convention Against Corruption (UNCAC) is making a tangible impact. Through UNCAC cooperation, Mongolia successfully recovered USD 01.3 million, which is now funding an orphanage and supporting children's education.

Авсан арга хэмжээ:

1.3 сая ам.доллар бүхий хөрөнгийг буцаан авсан. Лондон дахь орон сууцыг тогтвортой орлого (**сард 2,500 фунт**) болгох замаар "Энэрэл" асрамжийн газарт дэмжлэг үзүүлж байна.

Нөлөө:

300+ хүүхдийн орчин нөхцөлийг сайжруулж, орчин үеийн тоног төхөөрөмж, боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Жишээ нь:

Агааржуулагч, шинэ тавилга, сургалтын өрөөнүүд.
Гадаад хэл, спорт, мэргэжлийн сургалтууд.

Авлигын эрсдэлийн үнэлгээ:
"Эрдэнэт үйлдвэр" тогтмол хийж эхэлсэн.

Сургамж:
Авлигын эсрэг хамтын ажиллагаа нь бодит амьдралд эерэг өөрчлөлт авчирч болохыг харуулсан.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

	Үйл ажиллагаа	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
1	Зөвлөмж хүргүүлсэн тоо	33	14	15	10	47	45	32 /26 байгууллагад/	61
2	Зөвлөмжийн хэрэгжилттэй танилцсан байдал	-	21	21	12	16	35	25	45
3	Дүрэм, журам хянаж, санал хүргүүлсэн	98	43	18	18	42	63	68	111
4	Хянаж санал өгсөн ёс зүйн дүрмийн тоо	9	7	-	13	11	12	3	9
5	Сургалтад хамрагдсан тоо	8497	24,378	13,820	27,304	53,183	31,005	36,866	26,836
6	Гомдол мэдээлэл шалгасан тоо /Хүнд суртал, чирэгдэл/	-	-	-	-	117	237	112 -48.1 өмнөх жилээс буурсан	66
7	Хүнд суртал, чирэгдэлтэй төрийн үйлчилгээг арилгасан тоо	-	-	-	-	32	30	21	22
9	Мөрдөгчийн мэдэгдлийн мөрөөр ажилласан тоо	30	13	18	40	53	134	56	104
10	Ажилласан төрийн байгууллагын тоо	214	26	36	46	118	64	12	96
11	Хэлэлцүүлгийн тоо	4	25	35	5	8	5	7	2

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Авлигатай тэмцэх газрын УССГХ-ээс сүүлийн 2 жилийн байдлаар нийт 160.8 тэрбум төгрөгийн хохирол учрах байсныг таслан зогсоов.



	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Үр дүн
1	Улс хооронд ачаа тээвэр эрхлэх "С" зөвшөөрөл олгоход цахим систем нэвтрүүлэн холбогдох журмыг шинээр батлуулсан бөгөөд аж ахуйн нэгжүүдийн дунд зөвшөөрөл авах сонгон шалгаруулалтыг цахим систем бүрэн нэвтрүүлэх ажлыг АТҮТ-тэй хамтран гүйцэтгэсэн.	Төрийн байгууллагын хүнд суртал, чирэгдэл арилж, бүсдад давуу байдал олгох гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг таслан зогсоосон
2	Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, хугацааг сунгах зөвшөөрлийг 2018-2022 оны 9 сар хүртэл 118,261,000 төгрөгийн хураамжийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас үндэслэлгүйгээр авсныг тогтоон, тус шийдвэрийг хүчингүй болгов.	Барилгын компаниудаас жилд дунджаар 40 сая төгрөгийн хууль бус хураамж авч байсныг таслан зогсоосон.
3	"Барилга байгууламж барих ажлын төлөвлөлтийг сайжруулах, 2023 оноос эхлэн зураг төсөл хийгдээгүй ажлыг тендер сонгон шалгаруулалтад оруулахгүй байх, барилга байгууламжийн зураг төсөл хийгдээгүй байхад ажлын төсвийг урьдчилан таамаглан боловсруулж төсөвт суулгаж байгаа гэмт хэргийн шинжтэй үйлдлийг дахин гаргахгүй байх" албан зөвлөмж хүргүүлсэн.	Барилга, хот байгуулалтын яам жилд дунджаар 220 сая төгрөгийн өртөгтэй барилга байгууламж барих ажлыг "Барилгын зураг төсөл" хийгдээгүй байхад тендер сонгон шалгаруулалтад оруулж байсныг таслан зогсоож, хохирол гарахаас урьдчилан сэргийлсэн.
4	Зам тээврийн хөгжлийн сайдын А/222 дугаар тушаалаар батлагдсан "Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам"-ын дагуу азын дугаар олголтыг цэгцлэх зорилгоор цахим дуудлага худалдааг зохион байгуулдаг болов.	Азын гэх тодотголтой улсын дугааруудыг дуудлага худалдаанд оруулснаар 26,7 тэрбум төгрөгийн орлогыг тусгай санд төвлөрүүлсэн.
5	Баянзүрх, Налайх, Төв, Сонгинохайрханы 22-ын товчооны авто тээврийн хэрэгслийн авто зам ашигласны төлбөр хураан авах цахим үйлчилгээ дэх хүнд суртал, чирэгдлийг арилгах арга хэмжээ авах.	Нийслэлийн хүрээнээс гадна ажиллаж, амьдарч байгаа иргэдийн тээврийн хэрэгслээс Товчооны цахим төлбөр авах цэгээс чөлөөлөгдөж үнэ төлбөргүй болсон.
6	Эрүүл мэндийн яамны 5 төслийн нэгжид ажиллаж, эрүүл мэндийн салбарт гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 17 төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаатай танилцаж, Эрүүл мэндийн сайдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 асуудал бүхий зөвлөмж хүргүүлсэн.	Зөвлөмжийн дагуу 2024 оноос эхлэн 3 жилийн хугацаанд шинээр хэрэгжих төслийн салбар хүлээгч ТББ-уудыг сонгон шалгаруулах болсон

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

УССГХ-ИЙН ОНЦЛОХ АЖЛУУД

ТОВШ аппликэйшнд **НИЙСЛЭЛ УЛААНБААТАР** хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн, төрийн өмчийн 1900 байгууллагыг бүртгэсэн байна

НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ

Ирээдүйнхээ төлөө
Нэгдье
Сүхбаатарын талбай,
Үндэсний цэцэрлэгт хүрээлэн
2023.06.01

Эрүүл бие, эрүүл нийгмийн төлөө нэгдье
Сүхбаатарын талбай,
автомашингүй өдөр
2023.06.03

Эрүүл бие, эрүүл нийгмийн төлөө нэгдье хэт холын зайн марафон 2023
Сэлэнгэ аймаг 2023.06.10

ЦАГ ҮЕИЙН ШИНЖТЭЙ СУРТАЛЧИЛГАА

Иргэд олон нийтийн зүгээс Авлигатай тэмцэх газрыг сөргөөр хардаг сэтгэгдлийг эерэг болгохын тулд цахим системийг ашиглаж, олон нийтэд хүргэх чиглэлээр Үндэсний их баяр наадмын үеэр бөхчүүдийн гал дээр очиж контент хийв. Сошиал давлагаа үүсгэн албан ёсны пэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлж, байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлав.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

“ШУДАРГА ЁСНЫ КЛУБ”

- Нийслэлийн 5 дүүргийн 9 клуб байгуулсан.
- Орон нутагт 4 клуб

АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, ОЛОН НИЙТИЙН СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, “СУРГАГЧ БАГШ”

- Сүүлийн 3 жилийн байдлаар 250 гаруй сургагч багшийг салбарт бүрд бэлтгэсэн. Цагдаагийн байгууллагад тусгайлан сургалт хийх сургагч багшийг бэлтгэсэн.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр телевиз, fm радио, сонинтой гэрээ байгуулж, мэдээллийн сувгийн нэмэгдүүлэх

MGL радио, Авто радио 96.3 радио, Зохист аялгуу” 89.7, 103,6

Монгол HD, “Ийгл” телевиз, “Тв5” телевиз, MYOHPT /санамж бичиг/UBS

“Фантастик продакшн”, “Спорт продакшн” ХХК

Өнөөдөр сонин, Вип76 эксперт сэтгүүл

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

ГЭМТ ХЭРЭГ ГАРАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ;
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг үнэлэх арга зүйг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлнэ;
- Амьдралын хэв маяг, үзэл бодол, үнэт зүйлс, соёлд тулгуурлан соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж, үр нөлөөг нэмэгдүүлнэ;
- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, цахим платформыг судалж, нэвтрүүлнэ.;
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөлийг судлах, эрсдэл тодорхойлох, хяналт тавих ажлыг иргэний нийгэм, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, оролцоог нэмэгдүүлнэ.
- Үндэсний контентыг бүтээж, авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлнэ
- Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлнэ.
- Бүх түвшний сургалтын агуулга, хөтөлбөрт авлигыг үл тэвчих, ёс суртахууныг төлөвшүүлэх агуулга, сэдвийг олон улсын туршлага, үндэсний онцлогт нийцүүлэн тусгаж, дүн шинжилгээ хийж, үр нөлөөг үнэлнэ.
- Эрсдэлд суурилсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.
- Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэх ёс зүй, ёс суртахууны зөв төлөвшил олгоход чиглэсэн сургалт, нөлөөллийн хөтөлбөрийг насны ангилал, орчин үеийн чиг хандлагад нийцсэн байдлаар судалгаанд тулгуурлан боловсруулна.
- Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын түвшинд стандарт тогтоох холбогдох зохицуулалтыг бий болгоно.
- Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Боловсролын сургалтын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээг зохион байгуулж хэвшинэ.
- Сонгогчийн боловсрол, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын сүлжээ үүсгэн, хамтын ажиллагааг өргөжүүлж, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлнэ.
- Ирээдүйд тулгарч болзошгүй авлигын эрсдэл бүхий нөхцөл байдлыг үнэлэх аргачлалыг боловсруулж, бэлэн байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

Авлигын эсрэг НЭГДЭЕ
Үгүй гэж хэлээд өөрчилье!

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс





АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс

ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВСАН ТООН ҮЗҮҮЛЭЛТ



АНХААРАЛ ХАНДУУЛСАН
ТАНД БАЯРЛАЛАА

Аймшиг эрэл
НЭГДЭЕ
110

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Г.АРСЛАНХУЯГ
Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх албаны дарга, цагдаагийн хурандаа

Цагдаагийн байгууллага систем динамик загварчлалын туслалцаатайгаар ирээдүйн гэмт хэргийн гаралтын зураглалыг гаргадаг. Энэ программын зааварчилгааны дагуу гэмт хэрэг нь ойрын 10 жилд хүн амын өсөлттэй уялдан нэмэгдэх төлөвтэй байна.

Иймд цагдаа зөв стратеги, зөв бодлого, тактикийн дагуу ажиллах нь чухал бөгөөд үр дүн, хийх ажил нь тодорхой байх ёстой.

Цагдаагийн байгууллагаас зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Орчин цагийн цагдаагийн байгууллага байгуулагдсанаас хойш 104 жилийн хугацаанд өнгөрсөн, одоо, ирээдүйд урьдчилан сэргийлэх чиглэлээр баялаг түүх, уламжлал бүрдсэн. Бодит нөхцөл байдал, ирээдүйн зохицуулалтад нийцүүлэн цагдаагийн байгууллага урьдчилан сэргийлэх ажлыг үргэлж тэргүүлэх чиглэл болгон ажилладаг.

Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шинэ бодлого, философи, шийдвэр, стратеги нь цагдаагийн байгууллагын зарчмыг баримталсан байх ёстой бөгөөд үүнийг бид хүлээн зөвшөөрдөг. Орон орны нөхцөл байдал, соёл, амьжиргааны түвшин, хүчин зүйлсээс шалтгаалан тактик, стратеги харилцан ялгаатай байдаг.

Цагдаагийн байгууллага асуудалд суурилсан үйл ажиллагааг хэрэгжүүлж, гэмт хэрэг гарах үндсэн шалтгааныг арилгах, эрсдэлийг бууруулах чиглэлд онцгойлон анхаарч ажиллаж байна. Нийгэм, цаг үеийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн шинжлэх ухаанд суурилсан техник, технологийн дэвшлийг ашиглаж, шинэ сорилт, хөгжлийн бодлогод нийцсэн урьдчилан сэргийлэх болон гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохион байгуулах шаардлага бий болсон.

2025 оны байдлаар дэлхий даяар 5.56 тэрбум интернэт хэрэглэгч байгаа нь дэлхийн хүн амын 67.9 хувийг эзэлж байна. Үүний 5.24 тэрбум буюу 63.9 хувь нь сошиал медиа хэрэглэгчид байна (Statista, 2025).

Цахим орчны нөлөө нь гэмт хэргийн шинэ хэлбэрүүдийг бий болгож, урьдчилан сэргийлэх ажлын цар хүрээ, аргачлалд шинэчлэл хийх шаардлагыг тулгаруулж байна. DataReportal (2025) тайланд дурдсанаар, дижитал хэрэглэгчдийн өсөлт нь гэмт хэрэг, зөрчлийн тархалт, мэдээллийн нууцлалын асуудалтай шууд хамааралтай байгаа талаар онцолсон.

2023-2040 оны хооронд гэмт хэргийн гаралт жилд дунджаар 6 хувиар өсөх төлөвтэй байгааг “Т-21” системийн динамик загварчлалын үр дүн

харуулсан байна. Энэхүү хандлага нь Монгол Улсад урьдчилан сэргийлэх бодлого, аргачлалыг дахин боловсруулах шаардлагатайг харуулж байна.

Орчин цагийн цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг гарсны дараа арга хэмжээ авах бус, харин урьдчилан сэргийлэх, иргэдтэй хамтран ажиллах чиглэлд төвлөрөх болсон. Энэ өөрчлөлт нь цагдаагийн үйл ажиллагааны шинэ философи, байгууллагын стратегийн шинэ чиг хандлага болон төлөвшиж байна.

Урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй хэрэгжүүлснээр гэмт хэргийн гаралтыг бууруулах, нийгмийн сөрөг үзэгдлийг хязгаарлах боломжтой. Иргэдийн оролцоо, мэдээллийн системийн хөгжлийн үр дүнд гэмт хэргийн эрсдэлийг урьдчилан тооцоолох боломж бий болж байна.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хамааруулсан гэмт хэрэг, зөрчлийн ихэнхийг нэг дор бүрэн шийдвэрлэх боломжгүй байдаг. Иймээс боломжит бүхий л арга хэмжээг авч, хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Өнөөгийн байдлаар цагдаагийн байгууллага нийтдээ хагас сая орчим дуудлага, мэдээлэл хүлээн аваад байна. Дуудлага, мэдээлэл нь нийгмийн амьдралын нэгэн үзэгдэл бөгөөд тодорхой цаг хугацаа, газар байршилд давтамжтайгаар гарч буй зөрчил, дэг журмын алдагдлыг илэрхийлдэг чухал үзүүлэлт юм.

Цагдаагийн байгууллага дотоод бүтэц, зохион байгуулалтын хүрээнд урьдчилан сэргийлэх чиглэлээр хуульд заасан олон чиг үүргийг нэгтгэн, уялдуулан хэрэгжүүлж байна. Гэмт хэрэг гарсны дараа хөөцөлдөхөөс илүүтэйгээр түүний үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгах, мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах, төлөвлөлт, эрсдэлийг бууруулах, таслан зогсоох ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарч байна. Энэхүү арга барил нь олон улсын сайн туршлагад нийцэж, орчны аюулгүй байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн чухал алхам болж байна.

2025 онд цагдаагийн байгууллага урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэлээр тодорхойлон, шинжлэх ухаанд суурилсан, судалгаа, нотолгоонд тулгуурласан байх шаардлагатай. Иймд цагдаагийн байгууллага урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд судалгааны ажлуудыг давхар зохион байгуулж, үр дүнг бодлого, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байна.

Энэ онд таван үндсэн зорилтын хүрээнд хөгжлийн бодлого, арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлж, үр дүнг бодит шалгуураар үнэлэх ажлыг зохион байгуулж байна.

1. Давтамжтай гарч буй дуудлага, мэдээллийн асуудлыг судалж, үндэслэлтэйгээр шийдвэрлэх.

2. Иргэдийн мэдлэг, ойлголтын дутмаг байдлаас үүдэлтэй алдаа, зөрчлийг бууруулах. Энэ хүрээнд зөвхөн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх бус, харин ёс суртахуун, зан үйлийн соёл, дадал, хандлагад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

3. Хууль тогтоомж нь урьдчилан сэргийлэх ажлыг дүн шинжилгээнд тулгуурлан хэрэгжүүлэхийг шаарддаг тул цагдаагийн байгууллага дүн шинжилгээнд үндэслэсэн олон талт арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

4. Гэмт хэрэг дахин гарахаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, бодлого хэрэгжүүлэх.

5. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд инновац, шинэлэг арга хэрэгсэл, технологийг нэвтрүүлэх замаар үр нөлөөг нэмэгдүүлэх.

Мэдээлэл, нөлөөллийн ажилд зарим иргэд шүүмжлэлтэй ханддаг. Энэ оны 7 дугаар сард “Дүрмээ мөрдье” замын хөдөлгөөний аюулгүй байдал, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Тус нөлөөллийн арга хэмжээний үр дүнд гэмт хэрэг, зөрчил 37 хувиар буурсан ч дараагийн сараас өссөн үзэгдэл гарсан. Иймээс мэдээлэл, нөлөөллийн ажлыг тасралтгүй явуулах шаардлагатай. Тодорхой саруудад ч мэдээлэл, нөлөөллийн ажил, арга хэмжээ үр дүнтэй байж чаддаг. “Ятгах тусам нягтал, яараад яахав дээ”, “Дээрэлхэл дэлгэрэх ёсгүй”, “Соёл танаас эхэлнэ” зэрэг олон арга хэмжээ зохион байгуулж, олон нийтэд хүргэсэн.

Удирдлагын хяналтын систем буюу дашборд ашиглалтад орсноор статистикийн мэдээллийг зураглал хэлбэрээр бодит шийдвэр гаргалтад ашиглах боломж бүрдсэн. Монгол Улсын хэмжээнд бүх давтамжтай үйлдлийг нарийвчлан бүртгэж, гарч буй хор хөнөөлд үнэлэлт дүгнэлт хийж, хариу арга хэмжээ авдаг болсон. 25 мянган дуудлагын ард гэр бүлийн хүчирхийлэл, хүний эрхийн зөрчил, эд хөрөнгийн хохирол зэрэг олон асуудал илэрдэг бөгөөд энэ их мэдээлэл алга болдоггүй, харин цагдаагийн байгууллагын бодлогын үр дүнг илтгэдэг гэж үздэг.

АНУ, Зүүн өмнөд Азийн олон улс иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгмийн дэг журмыг сахиулах, хүний эрхийг хамгаалах ажлын хүрээнд камержуулалтын асуудлыг онцлон авч үздэг болсон. Мөн гадаад улс орнуудын “Smart City”, “Safe City” төсөл, камерын хяналтын нэгдсэн системийн туршлагыг харьцуулан судалсан.

Судалгааны үндсэн мэдээллийн эх үүсвэр нь Statista, DataReportal, MDPI, SSRN зэрэг олон улсын судалгааны байгууллагуудын тайлангууд

бөгөөд тэдгээрийг цагдаагийн байгууллагын “Ногоон бүс” төслийн өгөгдөлтэй уялдуулан боловсруулсан.

Цагдаагийн байгууллага иргэд олон нийтийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийг олон улсын стандарт түвшинд хүргэн камержуулах “Ногоон бүс” төслийг санаачлан 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

I шат: Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийг 2022 онд улсын төсвийн болон аж ахуйн нэгжийн оролцоо дэмжлэгтэйгээр камержуулж, камерын хяналтын дэд төвийг байгуулснаар гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэл 48.6 хувиар, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 37 хувиар тус тус буурч, гэмт хэргийн илрүүлэлт 41.9 хувиар өссөн.

II шат: Нийслэлийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг 12 хороог сонгон “Нэг хороо-Нэг сар” дэд төслийг иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран хэрэгжүүлсэн. Эдгээр хороодод төслийн хугацаанд 489 камер засварлаж, 476 камерын чигийг өөрчилж, 1714 камер, 800 анхааруулах тэмдэг шинээр байршуулсан. Тухайн хороодын камер ашиглалтад хийгдсэн туршилтаар нэг хүн 1000 метрт 40 удаа камерт бичигдсэн.

III шат: Төслийн энэ шатанд 2024 онд багтаан аймаг, нийслэлийн бүх баг, хороо, сум, дүүргийг аж ахуйн нэгжийн оролцоо дэмжлэгтэйгээр камержуулах, теле камерын хяналтын дэд төвүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар байгуулах зорилтыг тавин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар аймгуудад 33,709, нийслэлд 51,581, нийт 85,290 камер байршуулж, зорилтод түвшний хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Camera.police.gov программ хангамжийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлэн дээрх хяналтын камеруудыг бүртгэлжүүлсэн.

Камер ашиглалтад нэвтрүүлснээр 2024 онд 1,652 гэмт хэрэг, 8,393 зөрчлийг илрүүлж, 525 гэмт хэрэг, 878 зөрчлийг үйлдэл дээр нь таслан зогсоож, оршин суугаа газраасаа алга болсон 200 хүүхдийг олж тогтоон эцэг, эх асран хамгаалагчид хүлээлгэн өгөөд байна.

Камерын дараагийн үе шат буюу видео дамжуулах “Smart” ухаалаг программд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, одоогоор 21 аймгийн 20 аймагт “Теле камерын хяналын дэд төв”, нийслэлийн 9 дүүргийн 6 дүүрэгт “Теле камерын хяналын дэд төв”-ийг тус тус байгуулсан. Энэхүү программ нь нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулан ашиглаж байгаа дүрс бичлэгийн техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хадгалалтын аюулгүй байдал, хэвийн ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн.

Гэмт хэргийн төрлөөр авч үзвэл, хулгайлах гэмт хэрэг 2010 оноос 2020 он хүртэл тасралтгүй өссөн. Ковидын онцгой нөхцөлийг эс тооцвол хулгайлах гэмт хэрэг өсөх хандлагатай байсан ч, камержуулалт болон урьдчилан

сэргийлэх ажлын үр дүнд анх удаа буурч, хасах үзүүлэлттэй гарсан нь онцлох амжилт юм. Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн төрлүүд тэргүүлэх түвшинд хүрсэн бөгөөд залилах, хулгайлах, бусдын эрүүл мэнд, хүүхэд, гэр бүлийн эсрэг гэмт хэргүүд дээр онцгой бодлого гаргаж, идэвхтэй арга хэмжээ авч ажиллаж байна.

Үр дүн

ОХУ-ын Москва хотын камерын хяналтын системийн судалгаагаар (SSRN, 2024) гэмт хэргийн илрүүлэлт 70 хувь болж, гаралт 19.8 хувиар буурсан байна.

Мөн RFERL (2021)-ийн мэдээлснээр Москва хотод 213 мянга гаруй CCTV камер суурилуулсан бөгөөд хиймэл оюун ухаанд суурилсан нүүр таних системийн тусламжтайгаар хяналтын үр ашиг эрс дээшилжээ.

Хятад улсын Шэньжэнь хотын "Ухаалаг хот" төслийн хүрээнд (Hu, 2019) 50 сая гаруй мэдрэгч бүхий LTE сүлжээгээр холбогдсон хяналтын системийн үр дүнд гэмт хэрэг 85 хувиар буурсан байна.

Монгол Улсад "Ногоон бүс" төслийн хүрээнд камержуулалтын төвийг аймаг, дүүргийн түвшинд байгуулж, 2025 оны эхний 8 сарын байдлаар зарим төрлийн гэмт хэрэг 4–50 хувиар буурсан эерэг үр дүн гарсан байна.

Үүнд: хууль бусаар ан агнах гэмт хэрэг 11.8%, хулгайлах гэмт хэрэг 9.0%, эдийн засгийн гэмт хэрэг 35.7%, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 35.7% тус тус буурчээ.

Эдгээр үзүүлэлтүүд нь хиймэл оюун ухаан, теле хяналтын системийг үр дүнтэй ашигласнаар гэмт хэргийн гаралт буурч, цагдаагийн байгууллагын хариу арга хэмжээний хурд нэмэгдсэнийг харуулж байна.

Цахим шилжилт, инновац, хиймэл оюун ухаанд суурилсан хяналт, шинжилгээний системийг нэвтрүүлэх нь цагдаагийн байгууллагын стратегийн тэргүүлэх чиглэл болж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын шинжлэх ухаанч байдлыг баталгаажуулж байна.

ДҮГНЭЛТ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нь шинжлэх ухаанд суурилсан бодлого, судалгаа, технологийн дэмжлэгтэй байх шаардлагатай.

"Ногоон бүс" төсөл болон ухаалаг хяналтын систем нь гэмт хэрэг бууруулах, нийгмийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй арга болох нь нотлогдож байна.

Монгол Улсад "Ногоон бүс" төслийн хүрээнд камержуулалтын төвийг аймаг, дүүргийн түвшинд байгуулж, 2025 оны эхний 8 сарын байдлаар зарим төрлийн гэмт хэрэг 4–50 хувиар буурсан эерэг үр дүн гарсан байна.

Үүнд: хууль бусаар ан агнах гэмт хэрэг 11.8%, хулгайлах гэмт хэрэг 9.0%, эдийн засгийн гэмт хэрэг 35.7%, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 35.7% тус тус буурчээ.

Цаашид дараах чиглэлд анхаарах шаардлагатай

1. Хиймэл оюун ухаанд суурилсан хяналтын системийг өргөжүүлэх
2. Хохирогч, гэмт этгээдийн судлалыг гүнзгийрүүлэх
3. Судалгаанд суурилсан урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах
4. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх
5. Олон улсын туршлага, инновацыг үндэсний нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх.

ЭХ СУРВАЛЖ

1. Statista (2025). Digital population worldwide. https://www.statista.com/statistics/617136/digital-population-worldwide/
2. DataReportal (2025). Digital 2025: Global Overview Report. https://datareportal.com/reports/digital-2025-global-overview-report
3. Hu, R. (2019). The State of Smart Cities in China: The Case of Shenzhen. Energies, 12(22), 4375. https://doi.org/10.3390/en12224375
4. Surveillance Technologies in Autocratic Regimes: The Moscow AI Experiment and its Implications for Crime Control and Police Effectiveness. SSRN, 2024. https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=4789135
5. Foltynova, K. (2021). We See You! How Russia Has Expanded Its Video-Surveillance System. RFERL. https://www.rferl.org/a/russia-video-surveillance/31052482.html
6. “T-21 системийн динамик загварчлалын үр дүн”, Урьдчилан сэргийлэх алба, 2024.
7. Цагдаагийн байгууллагын “Ногоон бүс” төслийн тайлан, 2025.
8. Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн статистик (2013–2023)
9. Үндэсний статистикийн хороо: Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд
10. Mongolian Human Development Report, UNDP
11. Sterman, J. (2000). Business Dynamics: Systems Thinking and Modeling for a Complex World.
12. Forrester, J.W. (1961). Industrial Dynamics.

.


ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
"ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"
АСУУДЛААС – ШИЙДЭЛД
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Г.АРСЛАНХУЯГ
УЛААНБААТАР ХОТ
2025.09.30


CRIMES OF THE FUTURE
СИСТЕМИЙН ДИНАМИК ЗАГВАРЧЛАЛЫН ТУСЛАМЖТАЙГААР ИРЭЭДҮЙН ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТЫГ ЗУРАГЛАХ НЬ
МОНГОЛ УЛСЫН СҮЛИЙН
11 ЖИЛИЙН
нийгэм, эдийн засаг,
хүн ам зүйн суурь үзүүлэлтүүд,
гэмт хэргийн статистик мэдээлэл
10.000
хувьсагч
болон параметрүүд
12.000.000
өгөгдөл,
мэдээлэл
40 жил
дараах урьдчилсан
дүнслт, тооцоолол


CRIMES OF THE FUTURE
2025 оны 08-р сарын байдлаар дэлхий даяар 5.56 тэрбум интернет хэрэглэгч байгаа нь дэлхийн хүн амын 67.9%-ийг эзэлж байна.
Үүний 5.24 тэрбум нь буюу дэлхийн хүн амын 63.9% нь социал медиа хэрэглэгчид байна.
Эх сурвалж: https://www.statista.com/statistics/617136/digital-population-worldwide/
"Т-21" СИСТЕМ, ДИНАМИКИЙН ЗАГВАРЧЛАЛЫН ДАГУУХ ГЭМТ ХЭРГИЙН ПРОГНОЗ
2023-2040 он хүртэлх хугацаанд ГЭМТ ХЭРЭГ
70,000
52,500
35,000
17,500
жилд дундаар 6.0% ӨСӨХ төлөвтэй байна.


УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТҮҮХЭН ТОВЧООН
1921
1971
1971.07.17
50 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ
УЛСЫН ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТР
"ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДСНҮҮД"
"НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСЭЭС ҮЙЛДВЭРЛЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ"
ЗАРИМ ГЭМТ ХЭРГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ИТГҮҮЛЭЛТЭД ХОЛБОГДОХ НАРИЙВЧИЛСАН АСУУДАЛ
ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ АРГА НЬ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛТЭДЙЙГҮЙ УГ АЖЛЫГ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСТЭЙ, ІНЭГДСЭН БОДЛОГОД СУУРИЛЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВДАЛ ЧУХАЛ БАЙНА.

ОРЧИН ҮЕИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭ ҮЗЭЛ БОДОЛ (ФИЛОСОФИ) БАЙГУУЛЛАГЫН ШИНЭ СТРАТЕГИЙН

POLICE STRATEGIES / ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ

Community Policing	Problem-oriented Policing
Standard model	Focused Policing

Олон нийтэй хамтарсан	АСУУДАЛД ЧИГЛЭСЭН
Стандарт модел	Тевлерсен

Д/Д	ТӨРӨЛ	ЧИГЛЭЛ	ЗОРИЛГО	ЗАРЧИМ	АРГАЧЛАЛ
1	АСУУДАЛД ЧИГЛЭСЭН	ДАВТАН ҮЙДЭЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ	АСУУДЛЫН ШАЛТГААНЫГ АРИЛГАДАГ	ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТЭРГҮҮЛЭХ АЖИЛ	СУДЛАГААНД СУУРИЛНА
2	СТАНДАРТ ЗАГВАР	ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ	ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛТАН ШИЙДВЭРЛЭХ	ХУУЛЬ САХИЛАХ НИЙТЛЭГ ЧИГҮҮРЭГ	УЛАМЖЛАЛТ АРГА БАРИЛ


ЧИГ ХАНДЛАГА
AI
ЦАХИМ ШИЛЖИЛТ - ШИНЭ СОРИЛТ, ШИНЭ ХЭГЖЛИЙН БОДЛОГО ШААРДАЖБАЙНА
ИННОВАЦИ - ОРЧИНҮЕЙН НИЙТМИЙН ЗЭВСЭГ
СУДАЛТАА, ХЭГЖЛИЙН ТЕСЭЛ
ШИНЖЛЭХ ҮХААН, ТЕХНОЛОГИЙГ ДЭМЖИХ ТЕСЭЛ, ХӨТӨЛБӨР,
ХИЙМЭЛ ОЮУН ҮХААН АШИГЛАХ;
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ИЛРҮҮЛЭХ ТЕХНОЛОГИ


ТЭРГҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛ
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ
ДҮН ШИНЖИЛГЭЭ
ШАЛТГААН НӨХЦӨЛ
ДҮҮДЛАГЫН ДАВТАМЖ
НӨЛӨӨ БҮС
НӨЛӨӨЛТИЙН АЖИЛ
ХЯНАЛТ ТАВИХ ЭТГЭЭД
МЕНЕХЕР
ГЭМТ ХЭРЭГТЭН
ГЭМТ ХЭРТИЙН ГАЗАР
ГЭМТ ХЭРЭГ
ХОХИРОГЧ
ХАМГААЛАГЧ

ДҮНШИНЖИЛТЭЭНД СУУРИЛСАН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ

СУДАЛТАА, ДҮНШИНЖИЛТЭЭ

- ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ ТОГТООХ
- ГАЗАР НУТАГ ТОДОРХОЙЛОХ
- ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХАРИЛЦААГ ТОГТООХ
- ХОХИРОГЧ СУДЛАЛ
- ГЭМТ ЭЛТГЭЭД СУДЛАЛ
- ГЭМТ ҮЙЛДЭЛ СУДЛАЛ

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- АРИЛТАХ, ТАСЛАН ЗОГСООХ
- СААРМАГ ЖУУЛАХ
- СУРГАЛТ, СУРТАЛ НИЛТААА
- МӨДӨӨЛӨЛ, НӨЛӨӨЛӨЛ
- МӨДӨЛДӨЛ, ЗӨВЛӨМЖ
- ОРЧИН БҮРДҮҮЛЭХ

"ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Тодорхой хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, зорилго, зорилтод чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг ҮНДСЭН ЧИГЛЭЛ гэнэ.

ҮНДЭСЛЭЛ
Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
түүний удирдлагын тухай хууль 4.1.6–4.1.8, 4.1.10

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН 2025 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

- Нг. КАМЕРЖУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ТӨВ
- Хөөр. МӨДӨЛДӨЛ, ЗӨВЛӨМЖ
- Гурав. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ
- Дөрөв. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ
- Тав. ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААГ НЭМЭГДҮҮЛЭХ, СУРГАЛТ, НӨЛӨӨЛТИЙН АЖИЛ

"ARCGIS" "ДАШБОАРД"




Гомдол, мэдээлэл – 25,931
11.653
буюу 44.9%
ЭХНИЙ ХАГАС ЖИЛТЭЭС 2%-ИАР БУУРСАН
2500
2000
1500
1000
500
0
2179
1782
1105
1103
927
819
783
573
537
471
453
440
302
147
65
36
35
20
19
15
14
14
13
13
13
11
11
10
10
9
8
7
6
4
4
2
1
0
БГД-1
СХД-1
БГД-3
ХУД-1
СХД-2
БГД-2
БГД-2
БГД-1
ХУД-2
СХД-3
СГД-2
ЧД-2
СГД-1
ЧД-1
Хэнтий
Баян-Өлгий
Ховд
Өмнөговь
Сэлэнгэ
Дорнод
Дундговь
Увс
Архангай
Булган
Орхон
Өвөрхангай
Дорноговь
Тув
Сүхбаатар
Нөмрөг
Хөвсгөл
Дархан-Уул
Говь-алтай
Баянхонгор
Завхан
Багахангай
Говьсүмбэр
Багануур


ХУЛТАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
НОГООН БҮС


ЛОНДОНГИЙН CCTV КАМЕРЫН СУДАЛГАА
ТОО БАРИМТУУД
15,516
МЕТРОНЫ БУУДАЛД БАЙРЛАДАГ КАМЕРЫН ТОО
13
ATIS
ATMS
APTS
AVCS
CVOM
ETC
EMS
500,000
Лондогийн CCTV камерын тоо
2007-2010 хооронд
£300 MILLION
CCTV камер суурилуулсан
Дунджаар Лондогийн иргэн
CAUGHT ON CAMERA
300
камерт өртдөг
2 долоо хоногийн хугацаанд бичлэгүүдийг хадгалдаг
MON
TUES
WED
THUR
FRI
SAT
SUN


ОХУ-ЫН МОСКВА ХОТЫН CCTV КАМЕРЫН СУДАЛГАА
ХИЙМЭЛ ОЮУН УХААНД СУУРИЛСАН
180,000+
Камерын тоо
Телехяналтын тесөл 2012 оноос эхлэн 4 үе шаттай хэрэгжүүлсэн
Гэмт хэргийн 70 хувийг илрүүлж, гаралт 19,8 хувиар буурсан
AI
Телехяналтын системийн бодлого, төлөвлөлт, арчлалт, засвар үйлчилгээг Москва хотын захиргаа хариуцдаг.

НОГООН БҮС-КАМЕРЫН ХЯНАЛТЫН ТӨВ


ХИЙМЭЛ ОЮУН УХААН, УХААЛАГ ПЛАТФОРМ
АЮУЛТҮЙ ДҮҮРЭГ
Хүн таних функц
Тээврийн хэрэгсэл бүртгэх
Хиймэл оюун ухаан /AI/
Орчны хяналт
Видео аналитик /VA/
Боогнорол тодорхойлох
Замын хөдөлгөөний аналитик
Аудио аналитик


ТЕЛЕХЯНАЛТЫН СИСТЕМ АШИГЛАН
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ИЛРҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ
ХЯНАЛТЫН ЦЭГ
НЭГДСЭН ХЯНАЛТ УДИРДЛАГЫН ТӨВ
ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТЭС
ХУРДАН ШУУРХАЙ ИЛРҮҮЛЭХ
ХЯНАЛТ | НЭГДСЭН УДИРДЛАГА | АЮУЛГҮЙ БАЙДАЛ | ҮР АШИГ

ДАРААГИЙН ТЕХНИКЛЭГ СИСТЕМ ДАВУУТАЛ



- ХЯНАЛТЫН ҮЕ ШАТ ДАМЖИГДАГ БАЙХ
- 100% ХЯНАЛТ ХИЙГДЭХ БОЛОМЖТОЙ
- ЦАГ ХУГАЦАА БАГА ЗАРЦУУЛНА
- ХЭРЭГТЭГЧИЙН ТОО ХЯЗГААРГҮЙ
- ХАЙЛТЫН ИЛРЭЛТ ТОДОРХОЙ
- БҮХ КАМЕРУУДЫН ХЯНАЛТЫГ ИДЭВХЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ
- ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙГ ШУУД БАРИМТЖУУЛАХ, ТҮҮНИЙГ ЭРЭН ХАЙЖ ҮЙЛДВЭЛ ШУУРХАЙ


ЦАГДАГАЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Гэмт хэргийн статистик, илрүүлэлт (2025 оны эхний 08сар)
Хуль бусаар ан агнах гэмт хэрэг
-11.8%
БУУРСАН
Хулгайлах гэмт хэрэг
-9.0%
БУУРСАН
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг
-35.7%
БУУРСАН
Хөрөнгө завших гэмт хэрэг
-13.8%
БУУРСАН
Эдийн засгийн гэмт хэрэг
-35.7%
БУУРСАН
ЗАРИМ ГЭМТ ХЭРГҮҮД ӨМНӨХ ОНООС 4-50.0% БУУРСАН
ЭЕРЭГ ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА


АНХААРАЛХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ҮР ДҮН

Б.БАТЗОРИГ
Монголын Криминологичдын холбооны удирдах зөвлөлийн дарга, доктор, профессор

Гэмт явдал нь нэг улсын хүрээнээс хальж, үндэстэн дамнасан, дэлхий нийтийн асуудал болсоор ирснийг энд батлан хэлэх нь илүүц.[1] 1912 оны Гаагийн конвенцоос эхлэлтэй гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гэрээ, хэлэлцээрүүд батлагдсан[2] бөгөөд хэрэгжүүлэх олон талт үйл ажиллагааг тодорхой үе шаттайгаар авч хэрэгжүүлсээр ирсэн. Гадаад улс орнууд ч үндэсний хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, журам, бодлого, стратеги батлан хэрэгжүүлж, иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амар тайван амьдралын төлөө хүчин чармайлт гаргасаар байгаа билээ.

Монгол Улсын төр үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах,[3] хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад шаардлагатай эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх зэрэг үүргийг иргэдийнхээ өмнө хариуцах[4] ёстой гэж Үндсэн хуулиар тодорхойлсон. Үүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд 1997 онд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуультай цөөхөн улсын нэг болж байв. Түүнчлэн "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай", "Авлигын эсрэг тухай", "Садар самуун явдалтай тэмцэх тухай", "Хүн худалдаалахтай тэмцэх тухай", "Мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэлтэй тэмцэх тухай", "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай", "Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай", "Үйлдвэрлэх, олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай" зэрэг тодорхой төрлийн гэмт хэрэг, нийгмийн сөрөг үзэгдэлтэй тэмцэх хуулиуд батлажээ.[5]

Баталсан хууль, олон улсын гэрээ, хөтөлбөрийн тоотой харьцуулбал гэмт хэрэг, зөрчил буурах ёстой баймаар санагдах боловч бүртгэгдсэн гэмт хэрэг /цар тахлын үеийг эс тооцвол/ өссөн үзүүлэлттэй /зураг 1/[6] цаашид ч нэмэгдэх хандлагатай.

---

[1] Гэмт хэрэгтэй тэмцэх анхны олон улсын гэрээ нь 1912.01.23-ны өдөр 13 улс орон санал нэгтэйгээр баталсан "Хар тамхитай тэмцэх тухай олон улсын Гаагийн конвенц"
[2] НҮБ-ын зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (UNTOC), Хүний наймааны эсрэг протокол (UNTOC хавсралт), Галт зэвсгийн хууль бус эргэлтийн эсрэг протокол, НҮБ-ын Авлигын эсрэг конвенц (UNCAC), Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх конвенц (UN Convention Against Illicit Traffic in Narcotic Drugs and Psychotropic Substances)
[3] Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
[4] Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.
[5] https://legalinfo.mn/
[6] Үндэсний статистикийн хороо

Зураг 1. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт /улсын дүн/



Өнөөдөр та бүхэнтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоо болон урьдчилан сэргийлэх ажлын үр дүн гэсэн хоёр чухал сэдвийн хүрээнд ярилцаж, судлаачид, мэргэжлийн хүмүүстэй санал солилцох хариуцлагатай үүрэг надад оногдлоо.

Иргэний нийгмийн байгууллагын оролцоо

Миний хувьд иргэний нийгмийн байгууллагын хүрээнд хамаарах төрийн бус байгууллага, мэргэжлийн эвсэл холбоо, иргэдийн сайн дурын нэгдэл, нийгмийн хөдөлгөөн, хэвлэл мэдээллийн байгууллага, төрөөс хараат бус судалгааны хүрээлэн, их сургууль болон тэдгээрийн дэргэдэх судалгааны төвүүд, бодлогын судалгааны байгууллагуудаас **Төрийн бус байгууллагыг онцлон авч үзэж байна.**[1]

[1] Мэдээллийг 2022 оноос хойш Нийслэл болон 21 аймагт сургалт, судалгааны ажлын чиглэлээр ажиллах явцад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, иргэний нийгмийн байгууллага, хууль сахиулах болон прокурор, өмгөөлөгч, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдтэй уулзах, үйл ажиллагаатай нь танилцаж олж авсан болно.

Монгол Улсад иргэний нийгмийн байгууллагууд нь ардчилал, хүний эрх, байгаль орчин, авлигын эсрэг тэмцэл, эмэгтэйчүүд, хүүхдийн эрх, хөгжлийн бодлого зэрэг олон чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Харин гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр **дагнаж, тогтвортой ажилладаг төрийн бус байгууллага харьцангуй цөөн** бөгөөд **ялангуяа орон нутагт тэдний оролцоо хангалтгүй, идэвх сул** байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Та бүхний мэддэг буюу иргэний нийгмийн байгууллагын оролцооны хэлбэрүүдийн талаар товч мэдээлэл хүргээд дараагийн асуудалдаа орцгооё. Үүнд:

- Сургалт, чадвар хөгжүүлэх
- Олон нийтэд нөлөөлөх аян, компанит ажил зохион байгуулах
- Иргэдийн оролцоог дэмжих
- Сайн дурын тусламж үйлчилгээ
- Хамтын ажиллагааг дэмжих
- Хяналт-шинжилгээ, ил тод байдлыг хангах
- Судалгаа, мониторинг, үнэлгээ хийх
- Бодлого боловсруулах болон хэрэгжилтэд нөлөөлөх гэх мэт.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дээр дурдсан хэлбэрүүдээс сургалт, судалгаа, мониторинг, үнэлгээ хийх, хохирогчийн эрхийг хамгаалах, сайн дурын тусламж үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг иргэний нийгмийн байгууллагууд түлхүү хэрэгжүүлдэг. Гэвч эдгээр нь ихэвчлэн олон улсын байгууллагын богино хугацааны төсөл, хөтөлбөрт хязгаарлагддаг.

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д заасан санхүүжилтээр хийгдсэн гэх мэдээлэл нь гол төлөв сургалт, судалгааны хүрээнд хязгаарлагдаж, илүү өргөн хүрээний бусад үйл ажиллагаанд зарцуулдаггүй.

Төрийн байгууллагын давамгайлал ба эрсдэлүүд

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд зайлшгүй хэрэгжүүлэх бусад үйл ажиллагааг ямар байгууллага гүйцэтгэсээр байгааг та бүхэн мэдэж байж магадгүй. Энэ нь Цагдаагийн байгууллага юм. Тус байгууллага олон нийтэд нөлөөлөх аян, компанит ажил зохион байгуулах, иргэдийн оролцоог дэмжих, хамтын ажиллагааг зохион байгуулах, бодлого боловсруулах болон хэрэгжилтэд нөлөөлөх ажлын ачааллыг дангаараа үүрч байна.

Энэ нь богино хугацаанд үр дүнтэй байж болох ч[1] дараах сөрөг үр дагавартай байж болзошгүй.[2] Үүнд:

1. Иргэний нийгмийн байгууллагын орон зай шахагдаж, тэдний ажил төрийн байгууллагын үйл ажиллагаа мэт ойлгогдон, бие даасан байдал алдагдах эрсдэлтэй. Урьдчилан сэргийлэх ажил төрийн, цэрэгжсэн, албадлагын шинжтэй болсноор чөлөөт, олон ургальч оролцоо буурна.

2. "Цагдаа хийж байгаа юм чинь" гэх хандлага үүсэж, иргэдийн идэвх суларч, дэмжлэг буурах магадлалтай. Иргэдийн дуу хоолой хумигдаж, олон улсын байгууллагууд иргэний нийгмийн байгууллагад итгэхээс илүүтэйгээр төр, тэр дундаа цагдаагаар төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлэх сонирхолтой болох хандлагатай. Үүний улмаас иргэний нийгмийн байгууллагууд цагдаагаас хараат болох эрсдэл үүснэ.

3. Шүүмжлэл, хөндлөнгийн хяналт суларч, хариуцлагын тогтолцоо алдагдах магадлалтай. Улмаар иргэний нийгмийн хяналт буурч, хүний эрхтэй холбоотой оролцоо хязгаарлагдах, дарамт учрах эрсдэлтэй.

4. Иргэний нийгмийн байгууллагууд тогтвортой ажиллах, мэргэших боломжгүй болж, тэдний орон зайг цагдаагаас гадна прокурор, шүүх болон бусад хууль сахиулах байгууллагууд нөхөж эхлэх хандлага үүсэж болзошгүй.

5. Бодлого боловсруулах болон хэрэгжилтэд нөлөөлөх ажлыг цагдаагийн байгууллага тэргүүлэх үүрэгтэйгээр оролцох нь ажлын гүйцэтгэл, үүрэг даалгаврын биелэлт сайн байж болох ч хориглож, хязгаарласан, хүний эрхийг хязгаарласан эрх зүйн орчин давамгайлах эрсдэлтэй.

Иргэний нийгмийн байгууллагууд өөрсдийн идэвх санаачилгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа бөгөөд хүний наймаа, гэр бүлийн хүчирхийлэл, авлига, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Гэвч энэ нь төрийн зохицуулалт хангалтгүй байгааг илтгэж байгаа юм. Үүнийг зөвхөн санхүүгийн дэмжлэгийн хүрээнд хязгаарлаж ойлгох нь учир дутагдалтай.

"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, **төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог** тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршино" гэж заасан иргэний нийгмийн байгууллагын оролцоо гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд чухал үүрэгтэйг тодорхойлж байна.

---

[1] Community-Oriented Policing (COP)-ын талаар https://police.un.org/en/community-oriented-policing цахим эх сурвалжаас үзнэ үү.

[2] Oxford handbook topics in criminology and criminal justice. 2012. Tim Goddard, Andrea Headley "Community-Based Organizations and Crime Prevention" дэлгэрүүлэн үзнэ үү.

Гэвч Монгол Улсад иргэний нийгмийн байгууллагууд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх нэгдсэн мэдээлэл хомс бөгөөд тэднийг шагнаж, урамшуулсан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааны үр дүнгийн талаарх сүүдрийн тайлан илтгэл талаарх баримт төрийн холбогдох байгууллагын албан ёсны эх сурвалжид дурдагдсан зүйлгүй. Судалгааны явцад[1] гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнгийн талаар дараах асуултад хэрхэн хариуцсан байдлаас /хүснэгт 1/ үзвэл **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үнэлж, дүгнэдэг шалгуур үзүүлэлт, арга зүйн заавар** шаардлагатай гэдэгтэй бүгд санал нийлж байв.

Хүснэгт 1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүн.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэмжих шалгуур үзүүлэлт байдаг эсэх?	Төрийн ажил дүгнэдэг нийтлэг үзүүлэлт, тайланд үндэслэдэг. Судалгаа шинжилгээ хийдэг боловч хэт ерөнхий учир үр дүнг тооцоход хэцүү. Төвөөс өгсөн чиглэлээр л ажлаа хийдэг. Тогтсон шалгуур үзүүлэлт байдаггүй.
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн хэмжиж, үнэлдэг вэ?	Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлт аян, нөлөөллийн арга хэмжээний үе бага зэрэг буурдаг, иргэдийн ойлголт, хандлага нэмэгддэг. Хэрхэн өөрчлөгдөж байгааг хэмжих талаар мэдэхгүй байна. Нийтийн сүлжээний хандалтаар тодорхойлдог.
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэн хэмжиж, үнэлдэг вэ?	Удирдлагууд үнэлдэг.
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтын гарын авлага байдаг уу?	Сургалт зохион байгуулдаг. Гарын авлага тараадаг.[2] Оюунболд судлаачийн гарын авлага байдаг.[3]

Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь хүний идэвх санаачилгад тулгуурлахад хүргэж байх талтай.

Дүгнэлт

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоо дутмаг, тухайн үйл ажиллагаа нь төрийн байгууллага тэр дундаа хууль сахиулах байгууллагын идэвхтэй үйл ажиллагаанд тулгуурлаж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үнэлж, дүгнэдэг шалгуур үзүүлэлт, арга зүйн заавар боловсруулах шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, тогтвортой, мэргэшсэн байдлыг хангах, төрийн болон олон улсын байгууллагын дэмжлэгийг тэнцвэртэй хуваарилах

[1] Судалгаанд орон нутгийн Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан 11 албан хаагч, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 12 мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага

[2] Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс гаргасан гарын авлагын талаар мэдээллийг https://cccp.gov.mn/content/253 үзнэ үү.

[3] Г.Оюунболд, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй", УБ., 2017 он

зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг сайжруулахад тэргүүн ээлжид анхаарах асуудлыг дараах /зураг 2/ байдлаар тодорхойллоо.

Зураг 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах асуудал.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллага ажиллах эрх зүйн орчин

